3-96	Node Split Ratio		Number of subscribers served per optical node; affects signal strength.	Зангилааны хуваах харьцаа -Тухайн зангилаа цэгийг хуваан эзэмшиж буй хэрэглэгчийн тоо. Хэрэглэгчийн тоо нь олон бол үйлчилгээний чанар муу байна.
3-97	Noise Figure (NF)			Шуугианы үзүүлэлт- Системийн шуугианд ашигтай дохио өртөж буурах хэмжээ

3-98	Return Amplifier		Amplifier used in the upstream/return path to strengthen signals from subscribers.	Буцах өсгүүр-Хэрэглэгчээс ирэх дохиог өсгөх дээш урсгалын буюу буцах замд тавигддаг өсгүүр
3-99	Return Path / Upstream		Signal path from subscriber back to headend for interactive services.	Буцах зам / дээш урсгал- интерактив үйлчилгээний хувьд хэрэглэгчийн төхөөрөмжөөс толгой станц руу дамжих дохионы зам
3-100	RF Combiner		Merges multiple RF signals onto a single cable line.	RF нэгтгэгч - нэг кабель шугамаар олон RF дохиог нэгтгэн дамжуулах хэрэгсэл
3-101	RF Splitter Loss		Signal reduction caused by splitting a cable into multiple outputs.	Радио давтамжийн салаалагчийн алдагдал - Олон гаралтад чадлыг хувааж гаргах үед дохиог сулруулах үзүүлэлт
3-102	Subscriber Drop		Cable from distribution network that connects directly to a subscriber's home.	Хэрэглэгчийн шугам руу салаалах цэг -Хуваарилах шугамаас хэрэглэгч рүү салаалах холболтын цэг
3-103	Tap		Provides a controlled portion of the signal to a subscriber line.	Кабелийн телевизийн түгээх шугамаас дохионы тодорхой хэсгийг салган авч хэрэглэгч рүү дамжуулах зориулалттай пассив холболтын төхөөрөмж.
3-104	Trunk Amplifier Cascade		Series of amplifiers along the trunk to maintain signal quality over distance.	Гол шугамын каскадан өсгүүр - Алсад дохионы чанарыг хангах гол шугамын дагуу байрлах өсгүүрүүд
3-105	Trunk Line		Main high-capacity cable carrying multiple channels from	Толгой станцаас зангилаа руу олон сувгийг зөөвөрлөх их багтаамжийн кабель

3.4 Тоон Телевиз

	Англи нэр	Монгол нэр	Тайлбар	Засварлах санал
4-1	Low Density Parity Check	LDPC	Бага нягтралтай тэгш шинжийг шалгах, их хэмжээтэй шуугиан ба интерференцтэй үед үр дүнтэй код	Олон замын замхралттай ба шуугиан ихтэй сувагт алдааг засах зориулалттай бага нягтралтай тэгшийг шалгах код
4-2	Multiple Inputs Single Output	MISO	Олон оролт, дан гаралт	Олон оролт, нэг гаралт
4-3	Multi Physical Layer Pipe	MPLP	Олон физик давхаргат хоолой.	+ Хоёрдогч үеийн тоон өргөн нэвтрүүлгийн системд яригдах нэр томъёо бөгөөд системийн нэг RF сувгаар бие даасан физик түвшний олон хоолойг дамжуулах логик суваг. Өөрөөр хэлбэл хүлээн авалтын янз бүрийн нөхцөлд тохирсон үзүүлэлттэйгээр дамжуулах физик түвшний олон хоолойнуудыг нягтруулж нэг RF сувгаар дамжуулна. Жишээ нь PLP0 нь HDTV, PLP1 нь хөдөлгөөнт ТВ-ийн үйлчилгээ гэх мэт өөр өөр үйлчилгээг явуулна.

4-4	Future Extension Frame	Ирээдүйд өргөтгөх фрейм	T2 фреймүүд хооронд байрлана. Ирээдүйд ашиглана.	DVB-T2-ийн үндсэн үйлчилгээнд нөлөөлүүлэхгүйгээр нэг ижил RF сувгаар явуулах ирээдүйн шинэ технологийн эсвэл нэмэлт системд (шинэ модуляцийн систем эсвэл өгөгдлийн үйлчилгээ) зориулагдсан фреймийн нөөц орон зай
4-5	Fast Fourier Transform (FFT)	Фурьегийн Хурдан Хувиргалт	Фурьегийн Хурдан Хувиргалт	Дохионы спектр байгуулагчийг шинжлэх, OFDM зөөгчүүдийг модуляцлах ба демодуляцлах ба спекрийг хэлбэржүүлэх, зорилгоор Фурьегийн Дискрет хувиргалтыг (хугацааны функцээс давтамжийн функц руу эсвэл давтамжийн функцээс хугацааны функц руу хувиргах) хурдтай хийдэг математик алгоритм
4-6	Peak-to-Average Power Ratio	PAPR	OFDM системийн оргил ба дундаж чадлын харьцаа.	+
4-7	Reed Solomon Code	RSC	Рид Соломоны код, алдаа засварлах код	
4-8	Trellis Coded Modulation	TCM	Торон кодлолтой модуляц	Треллис кодлолтой модуляц- алдаа засварын битийг мушгиа кодлол тусламжтай оруулж, үүссэн битийн цувааг өндөр эрэмбийн төлөвийн диаграмд оноох үйлдэл хийгддэг алдаа засварын код. Өөрөөр хэлбэл зурвасын өргөнийг ихэсгэлгүйгээр алдаа засварын кодлол ба модуляцийг нэгтгэсэн үйлдэл

MNS 6886:2026

4-9	Turbo Product Code	TPC	Хемингийн блок кодоод үндэслэсэн код	Хоёр хэмжээст матриц хэлбэрт өгөгдлийн битүүдийг байрлуулж мөр мөрөөр (хэвтээ шалгах бит) дараа нь багана баганаар нь (босоо шалгах бит)өөр өөр (VCH, Хэмминг) блок кодоор кодлох үйлдэл
4-10	Packet identifier	PID	Багц тодорхойлогч. 13 бит талбай	MPEG-ийн дамжуулах урсгалын нэг багцын толгой мэдээлэл дэх уг багцын тээж яваа өгөгдлийг (дуу, дүрс, өгөгдөл) таних зориулалттай 13 битийн талбар
4-11	Program specific information	PSI	Программын тусгай мэдээлэл. Программын (суваг) тухай мета өгөгдөл бөгөөд MPEG дамжууллын урсгалын нэг хэсэг	MPEG-ийн дамжуулах урсгал дахь нэг программын видео, дуу болон бусад өгөгдлийг таньж хооронд нь холбож, STB, TV гэх мэт төхөөрөмж зөв ялгаж, тоглуулахад шаардлагатай мэдээлэл юм. Дамжуулах урсгал дах бүх хөтөлбөрийн жагсаалт (PAT), нэг хөтөлбөрийн (дуу, дүрс, өгөгдөл) нэгж урсгалуудын PID-ийн жагсаалт(PMT), нууцлал хийгдсэн хөтөлбөрийн PID -ийн жагсаалт (CAT), сүлжээний нэр, транспондерийн нэр гэх мэт сүлжээний мэдээллийн жагсаалтыг агуулна.

4-12	Service Description Table	SDT	Үйлчилгээ тодорхойлох хүснэгт	Хэрэглэгчийн хөтөлбөрүүдийн нэр төрөл нэмэлт мэдээллийг агуулах үйлчилгээний мэдээллийн нэг төрөл - үйлчилгээ тодорхойлох хүснэгт
4-13	Event information table	EIT	Үйл явдлын мэдээллийн хүснэгт	Үйл явдлын мэдээллийн хүснэгт- ТВ ба радиогийн программуудын хөтөлбөр , тэдгээрийн эхлэх хугацаа үргэлжлэх хугацаа, түүний тухай товч тайлбар зэргийг агуулах үйлчилгээний мэдээллийн нэг төрөл
4-14	Time and Date Table	TDT	Хугацаа ба огнооны хүснэгт	Тухайн цэг дээрх ертөнцийн цаг өдрийг дэлгэц дээр харуулах, хөтөлбөрийн хөтөчтэй программуудын цагийг синхрончлох, зөв цагт эхлүүлэх зорилгоор дамжууллын урсгал дотор бүх ТВ-ийн хүлээн авагч ба STB руу дамжигддаг Ертөнцийн цагийн тухай мэдээлэл агуулсан үйлчилгээний мэдээллийн нэг төрөл

MNS 6886:2026

4-15	Selection information table	SIT	Мэдээллийг сонгох хүснэгт	Сонголтын мэдээллийн хүснэгт- Сүлжээний мэдээллийн хүснэгт (NIT) , үйлчилгээ тодорхойлох хүснэгт (SDT) ба үйлчилгээний мэдээллийн бусад хүснэгт байхгүй үед үйлчилгээний (програмуудын) тухай суурь мэдээлэл агуулсан үйлчилгээний мэдээллийн нэг төрөл. Өөрөөр хэлбэл дамжууллын урсгалын дамжуулалт эхлэх мөчид буюу шалгах үед үйлчилгээний сонголтод хэрэглэгддэг маш товч үйлчилгээний мэдээллийн хүснэгт
4-16	Transport Stream Description Table	TSDT	Дамжууллын урсгалыг тодорхойлох хүснэгт	Дамжууллын урсгалыг бүхэлд нь тайлбарлах ерөнхий мэдээлэл ба тодорхойлогч үйлчилгээний мэдээллийн нэг төрөл бөгөөд байнга дамжигддаггүй сонголтоор дамжигдана.
4-17	Program map table	PMT	Программын зураглалын хүснэгт	Дамжууллын урсгал дотроос тухайлсан нэг программын дүрс дуу өгөгдлийн урсгалын хэсгийг олж авах тухай мэдээллийг хүлээн авагчуудад хүргэх үүрэгтэй. Нэг программын дуу дүрс өгөгдлийн нэгж урсгалуудын жагсаалт, өгөгдлийн шахалтын хэлбэр (MPEG2, H264/MPEG4, HEVC, AAC), өгөгдлийн багцын ID, хэрэв программ нууцлалтай бол нөхцөлт хандалтын мэдээлэл зэргийг заасан программын тусгай мэдээллийн (PSI) нэг хэсэг.

4-18	Program Association Table	PAT	0 PID кодтой багцад илэрнэ. MPEG декодер дамжууллын урсгалд ямар программ байгааг тодорхойлоход ашигладаг	Хөтөлбөрийн / программын нэгдлийн хүснэгт- Дамжууллын урсгал дах бүх программуудын лавлах мэдээлэл бөгөөд хүлээн авагчид программуудын программын зураглалын хүснэгт (PMT) -ийн байрлалыг хэлж өгөх программын тусгай мэдээллийн (PSI) нэг хэсэг.
4-19	Conditional Access Table	CAT	Нөхцөлт хандалтын хүснэгт	Төлбөртэй үйлчилгээний хандалтыг хянахын тулд нууцлагдсан мэдээллийн нууцлалыг тайлах түлхүүр үгийг олох Эрх олгох хяналтын (ECM) ба эрх олгох удирдлагын (EMM) мессежийг олоход шаардагдах программын тусгай мэдээллийн (PSI) нэг хэсэг.
4-20	Network PID	Network PID	Сүлжээний багцыг тодорхойлогч.	Дамжууллын урсгал дотор сүлжээний мэдээллийн хүснэгт (NIT)-ийг агуулж буй багцын ID. Өөрөөр хэлбэл өргөн нэвтрүүлгийн нэг сүлжээнд байгаа бусад дамжуулах урсгал, давтамж болон дамжуулах системийн тухай сүлжээний түвш+E25ний мэдээллийг хүлээн авагч олоход туслах үүрэгтэй. Товчхондоо өргөн нэвтрүүлгийн сүлжээг нийтэд нь тодорхойлох NIT-ийн мэдээллийг агуулсан багцын байрлалыг заагч
4-21	Program Map PID	Program Map PID	Программын зураглалын мэдээллийн багцыг тодорхойлогч	Программын зураглалын мэдээллийн багцыг тодорхойлогч- дамжуулах урсгалд байгаа тухайлсан программын PMT мэдээллийн байрлалыг тодорхойлогч

MNS 6886:2026

4-22	Section Syntax Indicator	SSI	Синтакс сонгох индикатор. 1 бит урт талбай	Сейкшн синтаксын тодорхойлогч - PAT, PMT, CAT гэх мэт үйлчилгээний мэдээллийн эхэнд байрлах 1 битийн тэмдэгт
4-23	Network ID	Network ID	Сүлжээ тодорхойлогч. 16 бит урт талбай.	Сүлжээний мэдээллийн хүснэгтэд дамжуулах урсгал ямар сүлжээнд хамааралтай болохыг заах өргөн нэвтрүүлгийн сүлжээнд оноогдсон 16 битийн таних үг
4-24	Section length	Секцийн урт	Секцийн байтын тоог тодорхойлно. 12 бит урт талбай	Үйлчилгээний мэдээлэл ба Программын тусгай мэдээллийн толгой мэдээлэлд байх сейкшн дэх нийт байтын тоог илэрхийлэх 12 битийн талбар
4-25	Network descriptors length	Network descriptors length	Сүлжээний дескрипторын урт. 12 бит урт талбай	Нийт сүлжээний тодорхойлогчуудын нийт уртын байтын тоог илэрхийлэх 12 битийн талбар
4-26	Transport stream loop length	Transport stream loop length	Транспортын урсгалын цагиргийн нийт урт. 12 бит талбай.	Дамжуулах урсгалын жагсаалтын давталтын урт-Нэг сүлжээнд хамаарах бүх дамжуулах урсгалын жагсаалтын тухай мэдээллийн байтын тоог илэрхийлэх 12 битийн талбар бөгөөд сүлжээний мэдээллийн хүснэгтэд дамждаг
4-27	Transport stream id	Transport stream id	Транспортын урсгалыг тодорхойлогч. 16 бит талбай	Дамжуулах урсгалын таних 16 битийн талбар
4-28	Original network ID	Original network ID	Анхдагч сүлжээг тодорхойлогч	Тухайн үйлчилгээг үүсгэсэн анхдагч сүлжээг таних 16 битийн таних үг (ONID)

4-29	Transport descriptors length	Transport descriptors length	Дамжуулалтыг тодорхойлогч урт. 12 бит талбай	Дамжуулах урсгалын тодорхойлогчийн урт-Тухайн дамжуулах урсгалтай холбоотой тодорхойлогчуудын үргэлжлэлийн нийт байтын тоог илэрхийлэх 12 битийн талбар
4-30	CRC 32	CRC 32	Тэгш шинжийг шалгах циклдсэн код. 32 бит талбай	CRC-32 Сүлжээний мэдээлэл ба программын тусгай мэдээллийн төгсгөлд дамждаг алдаа засварын тэгшийг шалгах 32 бит -Тэгшийг шалгах цикл код
4-31	Descriptor tag	Descriptor tag	Дескрипторын заагч. 8 бит талбай	Тодорхойлогчийн шошго - DVB системийн (PAT, PMT, CAT, NIT, SDT зэрэг) тодорхойлогчийн төрлийг заагч 8 битийн талбар
4-32	Descriptor length	Descriptor length	Дескрипторын урт. 8 бит талбай	Тодорхойлогчийн урт - тодорхойлогч бүр хэдэн тодорхойлох өгөгдлийн битийг агуулсныг заах 8 битийн талбар
4-33	Forward Error Code outer	FEC outer	Алдаанаас хамгаалах гадаад код. 4 бит талбай	Алдаа засварын гадаад кодлол- Дамжуулах урсгалын жагсаалтын давталтын урт дотор дамждаг сувгийн гадаад кодлолд ашиглагдсан кодын төрлийг илэрхийлэх 4 битийн талбар
4-34	Forward Error Code inner	FEC inner	Алдаанаас хамгаалах дотоод код. 4 бит талбай	Алдаа засварын дотоод кодлол- Дамжуулах урсгалын жагсаалтын давталтын урт дотор дамждаг сувгийн дотоод кодлолд ашиглагдсан кодын төрлийг илэрхийлэх 4 битийн талбар
4-35	Packet start code prefix	Packet start code prefix	Багц эхлэлийн кодын дагавар. 24 бит талбай	Багцын эхлэлийн кодын угтвар - MPEG систем дэх багцлагдсан нэгж урсгалын эхлэлийг таних 24 битийн талбар

MNS 6886:2026

4-36	Stream ID	Урсгалын тодорхойлогч	Программын урсгалын төрөл, дугаарыг заана. 8 бит талбай	Урсгалыг таних түлхүүр үг - багцлагдсан нэгж урсгалд орших дуу дүрс өгөгдлийн багцын төрлийг тодорхойлогч 8 битийн талбар
4-37	Packetized Elementary Stream	PES	Багцлагдсан энгийн урсгал	Багцлагдсан нэгж урсгал-программын шахагдсан дуу, дүрс, өгөгдлийн хандалтын нэгж (I,P,B зэргийг эсвэл 8 эсвэл 24 мсек-ийн үргэлжлэлтэй дуу)-ээс тогтох анхдагч урсгалуудаас үүсгэсэн багцуудаас тогтох урсгал
4-38	PES packet length	PES packet length	Багцлагдсан энгийн урсгалын багцын урт	Багцлагдсан нэгж урсгалын (PES) багцын урт - энэ талбарын дараанаас эхлэх багцын уртыг 16 битээр илэрхийлсэн талбар .
4-39	Optional PES header	Optional PES header	Сонгож багцалсан энгийн урсгалын толгой хэсэг	PES толгой мэдээлэлд сонголтоор дамжих талбар- Багцлагдсан нэгж урсгалын багц бүрд тогтсон талбаруудын дараа сонголтоор дамждаг, урсгал нууцлагдсан эсэх, өндөр давуу эрхийн тэмдэгт, зохиогчийн эрхийг заагч, эх сурвалжийг (анхдагч эсвэл хуулбар эсэх) заагч, үзүүлбэр эхлэх / декодлол эхлэх хугацааны тэмдэгт (PTS/DTS), нэгж урсгалын үүслийн хурд, PES-ийн толгой мэдээллийн өгөгдлийн урт гэх мэт мэдээллийг агуулна.

4-40	PES scrambling control	PES scrambling control	PES-ын скремблэлийн удирдлага. 2 бит талбай	Багцлагдсан нэгж урсгалын нууцлалын хяналт - Нууцлагдсан эсэхийг заагч 2 битийн талбар
4-41	PES priority	PES priority	PES-ын давуу эрхийг заана. 1 бит талбай	PES-ийн давуу эрх-Давуу эрхийг заагч 1 битийн талбар
4-42	PES CRC flag	PES CRC flag	PES-ын тэгш шинжийг шалгах флаг. 1 байвал тэгш шинжийн циклдсэн шалгалтын талбай байгааг заана. 1 бит талбай	PES-ийн тэгшийг шалгах тэмдэгт-PES багцын толгой мэдээлэлд тэгшиг шалгах кодын талбар байгаа эсэхийг заах 1 битийн талбар
4-43	PES extension flag	PES extension flag	PES-ын өргөтгөлийн флаг. 1 бит талбай	PES-өргөтгөлийн тэмдэгт -PES толгой мэдээлэлд сонголтоор дамжих талбарын дараа өргөтгөл хэсэг байгаа эсэхийг заах 1 битийн талбар
4-44	PES header data length	PES header data length	PES-ын толгой хэсгийн өгөгдлийн урт. 8 бит талбай.	PES толгой мэдээллийн өгөгдлийн урт - PES ачааллын талбар ба PES толгой мэдээллийн байнгын талбарыг тооцолгүйгээр PES толгой мэдээлэлд сонголтоор дамжих талбарт дамждаг PES толгой мэдээллийн өгөгдлийн уртын талбарыг (PES header data length) дагалдах мэдээллийн байтын тоо

MNS 6886:2026

4-45	ESCR and ES rate	ESCR and ES_rate	PES-ын дараалалд хамаатай синхрончлолын дохиог агуулсан талбайнууд	PES-ийн толгой мэдээлэл сонголтоор дамжих 2 талбар ESCR —Нэгж урсгалын хугацааны тулгуур (Elementary Stream Clock Reference)- Программын хугацааны тулгуур (PCR) - тай төстэй ч нэгж урсгалын хугацааны тулгуур бөгөөд системийн хугацаатай нэгж урсгалын декодлох ба үзүүлбэрийн хугацааг синхрончлох үүрэгтэй 33 битийн талбар. ES_rate (Elementary Stream Rate)- Нэгж урсгалын хурд -секунд дэх 50 байтын нэгжээр нэгж урсгалын өгөгдлийн хурдыг илэрхийлсэн 3 байтын талбар бөгөөд урсгалыг ямар хурдаар декодлохыг декодлуурт мэдэгдэх үүрэгтэй. -ES rate (bits/s)=ES_ratex50x8
4-46	ES rate	ES rate	Элементар урсгалын хурд. 22 бит талбай	хасах
4-47	PES private data flag	PES private data flag	PES багцын хувийн өгөгдлийн флаг. 1 байвал PES багцын гарчигт хувийн өгөгдөл байгааг, 0 байвал хувийн өгөгдөл байхгүй гэсэн үг. 1 бит талбай	PES багцын хувийн өгөгдлийн флаг. 1 байвал PES багцын толгой мэдээлэлд хувийн өгөгдөл байгааг, 0 байвал хувийн өгөгдөл байхгүй гэсэн үг. 1 бит талбар
4-48	PES private data	PES private data	PES-ын хувийн өгөгдөл. 16 бит талбай.	PES -ийн хувийн өгөгдөл- хэрэглэгчийн ба системийн мэдээллийг агуулах 128 битийн талбар. Энэ талбарын мэдээллийг MPEG2 стандарт тодорхойлоогүй боловч систем хөгжүүлэгч түүнийг нөөцлөх эсвэл системийн хувийн мэдээлэл дамжуулахад ашиглахаар тогтоосон байдаг.

4-49	PES extension field length	PES extension field length	PES-ын өргөтгөл хэсгийн урт. 7 бит талбай	PES өргөтгөлийн талбарын урт-PES толгой мэдээлэлд сонголтоор хувийн болон системийн өгөгдөл дамжих талбарын нэг хэсэг бөгөөд PES-ийн толгой мэдээллийн байнгын 9 байтын дараа нэгж урсгалын ачааллын өмнө дамждаг (1-30 байт) хувьсах урттай талбар
4-50	Stuffing byte	Stuffing byte	Стаффингийн байт. 1111 1111 бүрдэлтэй 8 битийн тогтмол комбинац бөгөөд тусгай шаардлагыг хангах зорилгоор түүнийг кодлох байгууламж оруулж өгнө	Нөхөлтийн байт-синхрончлолын байт-PES толгой мэдээллийн өгөгдлийн урт (PES_header_data_length) талбарыг дүүргэх эсвэл дамжууллын урсгалын TS 188 байт багц мэдээллийн байтаар дүүрээгүй үед тохируулгын талбарт нөхөх байтуудыг оруулна.
4-51	Sync byte	Синхро байт	0100 0111 бүрдэлтэй 8 битийн тогтмол талбай	Дамжууллын урсгалын багцын эхэнд байх дамжууллын багцын эхлэлийг декодерт таниулах 1 байтын талбар
4-52	Transport error indicator	Дамжууллын алдааны индикатор	1 байвал транспортын урсгалд наанадаж засварлагдаагүй 1 алдаа байгааг заана. 1 бит талбай	Дамжууллын алдааны индикатор (TEI) - дамжуулал ба демодуляц хийх явцад дамжууллын урсгалын багцад алдаа гарсан тухай хүлээн авагчид болон декодлуурт мэдэгдэх зориулалттай 1 бит бөгөөд түүний утга 1 байвал декодлуурт энэхүү багцыг декодлохгүй орхино:

MNS 6886:2026

4-53	Payload unit start indicator	Ашигтай ачааллын эхлэлийн индикатор	Ашигтай ачааллын эхлэлийн индикатор. 1 бит талбай	Ачааллын эхлэлийг заагч (PUSI)- 188 байтын дамжууллын багцын толгой мэдээлэл бүрийн 2 дох байтын 6 дах битэд дамждаг, 1 битийн талбар. 0-өмнөх багцын ачааллын хэсгийн үргэлжлэл байгааг 1 - шинэ ачааллын өгөгдлийн хэсэг эхэлж байгааг демультиплексор декодлуурт заана.
4-54	Transport priority	Дамжууллын давуу эрх	1 байвал өндөр давуу эрхтэй болохыг заана. 1 бит талбай	Дамжууллын давуу эрхийн заагч (PUSI)- 188 байтын дамжууллын багцын толгой мэдээлэл бүрийн 2 дох байтын 5 дах битэд дамждаг, 1 битийн талбар. 0 - хэвийн эрх 1 - бусад багцаас илүү давуу эрхтэй байгааг илэрхийлдэг. Хэрэв сүлжээнд алдаа гарвал өндөр давуу эрхтэй багцыг илүү өндөр кодлолоор түрүүлж дамжуулдаг. Буферийн санах ой хэт дүүрээд ирсэн үед ямар шийдвэр гаргахыг хүлээн авагч шийддэг.
4-55	Transport scrambling control	Дамжууллын scrambling control	Дамжууллын урсгалын багцын ашигтай ачааллын скремблэлийн горимыг хянана. 2 бит талбай	Дамжууллын нууцлалын хянагч- 188 байтын дамжууллын багцын толгой мэдээлэл бүрийн 3-р байт дах 2 битийн талбар. 00-нууцлалгүй 01 - нөөц 10-тэгш түлхүүр үгийг ашигласан нууцлал 11- сондгой түлхүүр үгийг ашигласан нууцлалтай болохыг хүлээн авах талд заана.

4-56	Adaptation field control	Дасамжийн (адаптацын) талбайн хяналт	Дамжууллын урсгалын толгой хэсгийн араас дасамжийн талбай юу, ашигтай ачаалал уу гэдгийг зааж өгнө	Тохируулгын талбарын хяналт - дамжууллын урсгалын толгой мэдээллийн 3-р байтын 4-5 дугаар битүүд бөгөөд 00-нөөц, 01- тохируулгын талбар TS багц агуулаагүй 10- TS багц зөвхөн тохируулгын талбар агуулна. 11- ачаалал ба тохируулгын талбар аль алиныг агуулна гэсэн утгатай.
4-57	Continuity counter	Тасралтгүй шинжийн тоолуур	Дамжууллын урсгал бүрд харгалзан утга нь өснө. 4 бит талбай	Үргэлжлэлийн тоолуур-дамжууллын урсгалын толгой мэдээллийн хамгийн сүүлийн 4 битийн талбар бөгөөд аравтын 0-15 утга авах ба ижил ID -тай багц орж ирэх тоолонд утга 1-ээр нэмэгдэнэ. Өөрөөр хэлбэл тодорхой нэг багцлагдсан нэгж урсгалыг 188 байтад хуваахад ижил PID бүхий дамжууллын урсгалын багцууд үүснэ. Тэдгээр багцын толгой мэдээлэлд үргэлжлэлийн тоолуурын утга 1, 1-ээр нэмэгдэх ба нэг нэгж багцлагдсан урсгал дуусахад энэ 4 байтын утга 0000 болж байдаг.
4-58	Generic Flow Control	GFC	Урсгалын ерөнхий хяналт. 4 бит талбай	эхэн үеийн тоон ТВ-ийн системд байсан сүүлийнхэд байхгүй учир хасах
4-59	Virtual Path Identifier	VPI	Виртуаль зам тодорхойлогч. 8 бит талбай	эхэн үеийн тоон ТВ-ийн системд байсан сүүлийнхэд байхгүй учир хасах
4-60	Virtual Chanel Identifier	VCI	Виртуаль суваг тодорхойлогч. 16 бит талбай	эхэн үеийн тоон ТВ-ийн системд байсан сүүлийнхэд байхгүй учир хасах
4-61	Payload Type Indicator	PTI	Ашигтай ачааллыг заагч. 3 бит талбай	эхэн үеийн тоон ТВ-ийн системд байсан сүүлийнхэд байхгүй учир хасах

MNS 6886:2026

4-62	Cell Loss Priority	CLP	Үүрийн (cell) алдагдлын давуу эрх. 1 бит талбай	эхэн үеийн тоон ТВ-ийн системд байсан сүүлийнхэд байхгүй учир хасах
4-63	Asynchronous Transport Mode	ATM	Асинхрон дамжууллын горим	эхэн үеийн тоон ТВ-ийн системд байсан сүүлийнхэд байхгүй учир хасах
4-64	Header Error Control	HEC	Толгой хэсгийн алдааны хяналт. ATM – ийн толгой хэсэг дахь алдааг засах зориулалттай. 8 бит талбай	эхэн үеийн тоон ТВ-ийн системд байсан сүүлийнхэд байхгүй учир хасах
4-65	Slice countdown field	Slice countdown field	Зүсэлт татах талбай. 1 байт талбай	эхэн үеийн тоон ТВ-ийн системд байсан сүүлийнхэд байхгүй учир хасах
4-66	Data piping	Data piping	Өгөгдөл дамжууллын шилжүүлэг	Өгөгдөл дамжуулах хоолой- MPEG-TS багцаар интерактив контент эсвэл программ хангамжийн шинэчлэлт гэх мэт нэмэлт өгөгдлийн үйлчилгээг тоон өргөн нэвтрүүлгийн системээр дамжуулах арга. Түүний жишээ бол дамжуулах урсгалаар IP өгөгдлийг дамжуулах MPE орно.
4-67	Data streaming	Өгөгдлийн урсгал	Их хэмжээтэй өгөгдөл PES багцад тасралтгүй урсгал хэлбэртэй байна	Өгөгдлийн урсгал- өгөгдлийг хугацаа ба дарааллыг нь алдагдуулахгүй тасралтгүй дамжуулах арга бөгөөд VOD болон бодит хугацааны дамжуулалд голчлон хэрэглэгдэх ба өгөгдлийн хоолойгоор хэрэгжиж болно.

4-68	Multiprotocol Encapsulation	Олон протоколын битүүмжлэл	Янз бүрийн протоколын өгөгдөл, толгой хэсгүүд MPEG-2 дамжууллын багц дотор багтана	Олон протоколын хавсаргалт- дамжуулах урсгалаар олон протоколын тухайлбал IP багцыг дамжуулахдаа дамжуулах урсгалын багцуудад хувиргаж дамжуулах арга. Энэ нь өргөн нэвтрүүлгийн системээр интернэт үйлчилгээ хүргэх, программ хангамжуудын шинэчлэл, интерактив аппликейшнуудэд хэрэглэгддэг
4-69	Data carousels	Өгөгдлийн карусель	Нэвтрүүлэх файл бүрийг циклэн давталттайгаар тэнцүү урттай хэсгүүдэд хуваана	Өгөгдлийн цикл дамжуулалт- тоон өргөн нэвтрүүлэгч өгөгдлийн ижил блокийг хүлээн авагч дурын хугацаанд хүлээн авч байхаар давталттай дамжуулах арга. Энэ нь программын хөтөч, программ хангамжийн шинэчлэлт хийхэд нийтлэг ашиглагддаг.
4-70	Data broadcast ID		Өгөгдөл дамжууллын тодорхойлогч	Өгөгдлийн өргөн нэвтрүүлгийн ID-дамжуулж буй олон үйлчилгээнүүдээс хэрэглэгчийн сонгосон үйлчилгээний өгөгдлийн урсгалыг хүлээн авагчид зөв сонгоход хэрэглэгдэх таних үг.
4-71	Text char	Text char	Өгөгдлийн нийлэгдэхүүнийг тодорхойлох текст бүхий тэмдгүүдийн талбайн цуваа	Текстийн тэмдэгт - тоон өргөн нэвтрүүлгийн үйлчилгээнд тухайлбал цахим хөтөч, субтитр, интерактив апп-ууд зэрэгт хэрэглэгддэг текстийн (үсэг, тоо, бусад тэмдэгт) тэмдэгт. Текстийн тэмдэгтүүдийн урсгал байдлаар дамжигдах ба хүлээн авагч түүнийг хэрэглэгчид уншигдаж байхаар эвлүүлж сэргээдэг.

MNS 6886:2026

4-72	Teletext type	Телетекстийн төрөл	Телетекстийн төрөл. 5 битийн талбай	Телетекстийн төрөл- тоон өргөн нэвтрүүлгийн системд хэрэглэгддэг телетекстийн (цаг агаар, мэдээ, цахим хөтөч) үйлчилгээний төрөл ба формат. Энэ нь контентын төрөл, кодлол түүнийг хэрхэн зөв сэргээж дэлгэцэд харуулах тусална.
4-73	Teletext magazine number	Телетекстийн байрын дугаар	Телетекстийн байрын дугаар.3 бит талбай	Телетекстийн төрөл- тоон өргөн нэвтрүүлгийн системд хэрэглэгддэг телетекстийн (цаг агаар, мэдээ, цахим хөтөч) үйлчилгээний төрөл ба формат. Энэ нь контентийн төрөл, кодлол түүнийг хэрхэн зөв сэргээж дэлгэцэд харуулах тусална.
4-74	Teletext page/ magazine number	Телетекстийн хуудасны дугаар	Телетекстийн хуудасны дугаар. 8 бит талбай	Телетекстийн хуудасны/ сэтгүүл дугаар- телетекстийн хуудаснуудыг таних зохион байгуулахад хэрэглэгддэг телетекстийн хаяглалтын хэсэг. Телетекстын сэтгүүл бүр нь (00-99) 100 хүртэл хуудсаар зохион байгуулагдах ба сэтгүүлийн дугаар (1-8) нь ямар сэтгүүлийн хуудас болохыг зааж хүлээн авагч; зөв хуудсыг хурдан таньж олоход тусална. Телетекстийн хаяг нь сэтгүүлийн дугаар+хуудасны дугаар байна.
4-75	Data identifier	Өгөгдлийг тодорхойлогч	Өгөгдлийг тодорхойлогч. 8 бит талбай	Өгөгдөл тодорхойлогч - Дамжууллын урсгалд дамжигдаж буй өгөгдлийн төрлийг (телетекст гарчиг, интерактив апп, программын шинэчлэл болон бусад нэмэлт өгөгдлийн үйлчилгээ) заах 1 эсвэл 2 байтын талбар

4-76	Data unit id	Өгөгдлийн нэгжийн тодорхойлогч	Өгөгдөл оруулах төрлийг тодорхойлогч. 8 бит талбай	Өгөгдлийн нэгжийн тодорхойлогч - өгөгдлийн урсгал доторх тодорхой өгөгдлийн нэгжийг таних талбар. Тухайн өгөгдлийн төрөл дотор байгаа өгөгдлийн нэгж хэсгийг ялгах ба хүлээн авагч нь зөв өгөгдлийн блокуудыг сонгож нэгтгэхэд тусална.
4-77	Data unit length	Өгөгдлийн нэгжийн урт	Өгөгдлийн байтын урт. 8 бит талбай	Өгөгдлийн нэгжийн урт - өгөгдлийн урсгал доторх өгөгдлийн нэгжид хэдэн байт агуулагдаж байгааг илэрхийлсэн утга бөгөөд дараагийн өгөгдлийн нэгж хаанаас эхлэхийг заана.
4-78	Reserved future use	Reserved future use	Ирээдүйд хэрэглэх нөөц	+
4-79	Field parity	Талбайн тэгш шинж	Талбайн тэгш, сондгойн шинж. 1 байвал кадрын эхний талбай, 0 бол 2-р талбай. 1 бит талбай	Талбайн тэгшийг илэрхийлэгч- Мөр алгасах дэлгэлттэй дүрсийг дамжуулахад фреймд сондгой эсвэл тэгш талбайн видео дамжиж байгаа эсэхийг заана.
4-80	Line offset	Мөрийн офсет	Өгөгдлийн багцтай мөрийн дугаар. 5 бит талбай	Мөрийн шилжилт/ байрлал- Дэлгэц дээр текст эсвэл график элемент эхлэх босоо байрлалыг заана.
4-81	Teletext data unit	Телетекст өгөгдлийн нэгж	Өгөгдлийн нэгжийн тактын синхрончлолын импульсын дарааллыг дагалдсан талбай	Телетекст өгөгдлийн нэгж- телетекстийн хуудас бүр дэлгэц дээрх нэг мөрд харгалзан нэгжүүдэд хуваагдана.

MNS 6886:2026

4-82	Default composition page id	Default composition page id	Хэвшмэл бүрдэлтэй хуудсыг тодорхойлогч	Үндсэн бүрдлийн хуудасны ID- DCPID - үзэгч телетекстийг идэвхжүүлэхэд автоматаар дэлгэц дээр үзүүлэгдэх 16 битийн урттай телетекстийн хуудасны таних үг бөгөөд дамжууллын урсгалын үйлчилгээг тодорхойлох хүснэгт (SDT) ба программын зураглалын хүснэгт (PMT) дотор дамжина. Тэрээр хүлээн авагчид телетекстийн үйлчилгээний үндсэн буюу нүүр хуудсыг зааж өгнө.
4-83	Default ancillary page id	Default ancillary page id	Хэвшмэл туслах хуудсыг тодорхойлогч	үндсэн-нэмэлт хуудасны ID- DAPID - дамжууллын урсгалын үйлчилгээг тодорхойлох хүснэгт (SDT) ба программын зураглалын хүснэгт (PMT) -ийн телетекстийн тодорхойлогч дотор дамждаг 16 битийн талбар. Тэрээр хүлээн авагчид телетекстийн нэмэлт (субтитр, график өгөгдөл зэрэг нэмэлт мэдээлэл) контентийн хуудсыг зааж өгнө.
4-84	ISO 639 language code	ISO 639 language code	Субтитрийн хэлийг тодорхойлогч код. 24 бит талбай	ISO639 хэлний код - үйлчилгээний бүрэлдэхүүн хэсэг (дуу, субтитр эсвэл телетекст)- т ашиглагдсан хэлийг таних 24 битийн талбар . Тухайлбал Mongolian- "mon" 0x6D6F6E

4-85	Subtitling extension flag	Subtitling extension flag	Субтитрийн өргөтгөлийн флаг. 1 байвал 16 бит урттай өргөтгөх талбай байгааг заана. 1 бит талбай	субтитрийн өргөтгөлийн флаг- дэвшилтэт субтитрийн үйлчилгээ, олон бүсийн субтитр зэрэг субтитрийн өргөтгөсөн формат хэрэглэсэн эсэхийг заах PMT-ийн субтитрийн тодорхойлогч дотор дамжих 1 битийн талбар. Энэ битийн утга 1 байвал нэмэлт хэл, өнгө хэлбэрээр тодотгосон тодорхойлолт зэрэг дамжиж байгааг заана. 0 байвал системийн үндсэн субтитрийн бүтэц ашиглагдаж байгааг илэрхийлнэ.
4-86	ISO 2375 code	ISO 2375 code	Тэмдэгтийн цуглуулгын бүртгэлийн дугаарыг заана	ISO 2375 код- хэлний код биш боловч тэмдэгт үсэгнүүдийн кодлолын системийг таних бүртгэлийн дугаар байна. Өөрөөр хэлбэл субтитр ба телетекстийн дамжигдаж буй үсэг тэмдэгтүүдийн формат (латин, кирилл, грек, араб)
4-87	Composition page id	Composition page id	Хэвшмэл бүрдэлтэй хуудас тодорхойлогч	Бүрдлийн хуудасны таних үг- Субтитрийн хуудастай холбоотой, дамжууллын урсгалын программын зураглалын хүснэгт (PMT) -ийн субтитрийн тодорхойлогч дотор дамждаг 16 битийн талбар. Объектын байрлал, өнгөний код, бүс, объектын тодорхойлолт зэрэг мэдээллийг декодлуурт мэдэгдэх үүрэгтэй.

MNS 6886:2026

4-88	Ancillary page id	Ancillary page id	Туслах хуудсыг тодорхойлогч	Нэмэлт хуудасны таних үг- үндсэн субтитрийн хуудасны нэмэлттэй холбоотой, дамжууллын урсгалын программын зураглалын хүснэгт (PMT) -ийн субтитрийн тодорхойлогч дотор дамждаг 16 битийн талбар. Нэмэлт субтитрийн өгөгдөл, үндсэн субтитрийн бүсийн хувилбар зэрэг мэдээллийг декодлуурт мэдэгдэх үүрэгтэй.
4-89	Data alignment indicator	Өгөгдөл тэгшитгэх индикатор	1 байвал субтитрийн хэсгүүд PES багцуудад харьцангуйгаар тэгшлэгдсэн болохыг заана	Дамжуулах урсгалын ачаалал дотор PES толгой мэдээллийн флаг дотор дамждаг 1 битийн талбар бөгөөд PES ачаалал эхэлж байгаа эхний байтыг кодлогдсон дуу дүрсийн эхлэлтэй давхацсан эсэхийг зөөнө. DAI=1 бол PES ачаалал PES өгөгдлийн нэгжийн эхлэлтэй давхцана (Ихэвчлэн шинэ хандалтын нэгж эхлэх бүрд). DAI=0 бол давхцуулах албагүй өмнөх PES багцын үргэлжлэл явж буйг илтгэнэ. Декодлуур видео болон дууны нэгж урсгалын заагийг декодлуурт мэдэгдэх үүрэгтэй.
4-90	Time stamp of subtitle	Time stamp of subtitle	Субтитрийг үзүүлэх хугацааны тэмдэглэгээ	Субтитрийг үзүүлэх хугацааны тэмдэгт
4-91	Forward Error Correction	FEC	Алдаанаас шууд хамгаалах код	Алдаа шууд засах код
4-92	Symbol rate	Тэмдэгтийн хурд	Нэгж хугацаанд дамжих тэмдэгтийн хурд	Нэгж хугацаанд дамжих тэмдэгтийн тоо

4-93	Discrete Cosine Transform	DCT	Дискрет Косинус Хувиргалт. MPEG дохионы суурь хувиргалт ба аналог дүрсийг тоон эквивалентад шилжүүлдэг	Дискрет Косинус Хувиргалт. - төгсгөлөг тоотой өгөгдлийн цэгүүдэд Фурьегийн хувиргалтаар косинус байгуулагчийг тооцож гаргах математик хувиргалт. Энэ хувиргалтаар дүрсийн элементүүдийн утга давтамжийн байгуулагчуудад хувирна.
4-94	Differential Pulse Code Modulation	DPCM	Дифференциал импульс кодын модуляци	+

3.5 Тоон радио өргөн нэвтрүүлэг (DAB)

	Англи нэр	Монгол нэр	Тайлбар	Засварлах санал
5-1	AAC			Дууны дэвшилтэт кодлол -олон сувгийн дууг чанар алдагдуулахгүйгээр 320кбит/сек хурдаар дамжуулах зорилготой 8-96 КГц-ийн дискретлэлийн давтамжтай, 1024 дискретийн DCT хийдэг MPEG-2 стандартын дууны кодлол
5-2	AAC+/HE-AAC			спектрийн зурвасын хуулбар ба параметран шахалт гэсэн 2 аргыг ашиглах MPEG-4 стандартын өндөр үр ашигт дууны кодлол

MNS 6886:2026

5-3	Access Control System	ACS	Хандалтын хяналтын систем. Тухайлсан багц дүрмээр нөхцөлт хандалтыг удирдах, хандалтын үсгэн мэдээллийг шалгана.	Хандалтын хяналтын систем - тоон өргөн нэвтрүүлгийн системд тодорхой үйлчилгээнд зөвшөөрөлгүй хандалтаас сэргийлэх нууцлал хамгааллын механизм бөгөөд тоон дууны өргөн нэвтрүүлэгч төлбөртэй ба нууцлалын үйлчилгээнд зөвхөн баталгаажсан хэрэглэгч ба хэрэглэгчийн төхөөрөмжийг нэвтрүүлэх систем. ACS-ийн нөхцөлт хандалтын танигч нууцлалын параметрууд, хяналтын үг, эрх олгох мессежнүүд нь FIC -ээр дамжина.
5-4	Alarm	AL	Аюулын дохиолол	Дохиолол - өргөн нэвтрүүлгийн сувгаар явж буй дуу болон өгөгдлийн үйлчилгээнүүдийг тасалж ачаалал тасарсан, аюулын дохио, цаг уур байгалийн гамшигт үзэгдлийг зарлан мэдээлэх зорилготой яаралтай буюу аюулын сэрэмжлүүлэг мэдээллийг дамжуулах тусгай дохиолол. Энэ нь сэрэмжлүүлэх мэдээлэл явуулж байгааг илэрхийлсэн дохиоллын флаг, сэрэмжлүүлгийн төрөл, сэрэмжлүүлэг мэдээллийг дамжуулж буй дэд суваг зэрэг мэдээлэл багтана.
5-5	Alias component	Давхарласан нийлэгдэхүүн	Найквистын дутуу самналтын толин дохионы багцын үр дүн	Давхацсан бүрдэл - нэг нягтруулга доторх өөр үйлчилгээнд хуваан хэрэглэх үйлчилгээний нэг бүрдэл хэсэг. Өөрөөр хэлбэл 2 өөр үйлчилгээнд ижил дуу эсвэл өгөгдлийг хэрэглэхийг хүссэн үед спектр ашиглалтыг сайжруулах үүднээс энэ бүрдэл хэсэг хэрэглэгдэнэ.

5-6	Announcement cluster	Зар мэдээллийн кластер	Нэг зар мэдээний сааталтын хугацаанд багтах бүлэг үйлчилгээнүүд	Зар мэдээллийн кластер - Үйлчилгээний мэдээллийн системийн динамик шошгын хэсэгт дамждаг бөгөөд зар мэдээлэл явах дууны үйлчилгээг таних үг (service ID), зар мэдээллийн төрөл (ачаалал, мэдээ, аюулын сэрэмжлүүлэг), зар мэдээллийн эхлэх хугацаа, үргэлжлэл, хэр давтан дамжилтын хугацаа зэрэг үйлчилгээтэй холбоотой зар мэдээллүүд. Энэ мэдээлэл хүлээн авагчид тухайн сувагт чухал мэдээлэл дамжихыг анхааруулдаг.
5-7	Announcement Support flags	ASu	Зар сурталчилгааны дэмжих флаг. Зар сурталчилгааны мэдээллийг заах (төлөв заах битүүд)	Зар мэдээллийг дэмжих флаг - DAB үйлчилгээний дэмжиж буй зар мэдээллийн төрлийг илэрхийлэх тэмдэгт ба үйлчилгээг автоматаар таслан зогсоож тохирох зарлан мэдээллийг дамжуулахыг хүлээн авагчид мэдэгдэх үүрэгтэй.
5-8	Announcement Switching flags	ASw	Зар сурталчилгаа сэлгэх флаг. Зар сурталчилгааны мэдээллийг солих (төлөв заах битүүд)	Зар сурталчилгаа сэлгэх флаг - зар мэдээлэл явж буй үйлчилгээ ба үйлчилгээний бүрдэл хэсгийг заадаг FIC дотор динамикаар дамждаг талбар бөгөөд зар мэдээллийн эхлэл төгсгөлд сувгийг үндсэн суваг руу автоматаар сэлгэн залгадаг.

MNS 6886:2026

5-9	Application Type	AppTy	Хэрэглээний төрөл	Аппликейшний төрөл - тухайн үйлчилгээний бүрдэл хэсгийн зөөж буй өгөгдлийн ба аппликейшний төрлийг заах 16 битийн талбар
5-10	Assignment operator	Хуваарилах оператор	Хуваарилах оператор	Оноолтын оператор -иж бүрдлийн үндсэн үйлчилгээнд үйлчилгээний бүрдэл хэсгүүд (дуу, өгөгдөл, зар мэдээлэл зэрэг) ийн оноогдсон байдлыг заах үйлчилгээний FIC -ийн дотор дамжигддаг талбар
5-11	Audio bit stream	Дууны бит урсгал	Дууны дохионы бит урсгал	Дууны битийн урсгал-DAB-аар дамжих шахагдсан дууны тоон өгөгдлийн урсгал
5-12	Audio frame	Дууны хүрээ	8, 24 мс үргэлжлэх дууны урсгал (48 кГц давтамжаар самнасан эсвэл 48 мс (24 кГц давтамжаар хэсэгчилсэн) , 2 дугаар төвшний дууны кодлолын дохиог багтаасан ISO/IEC 11172-3 [3], ISO/IEC 13818-3 [11] стандартуудын шаардлагыг хангах бөгөөд 1152 дараалсан хэсэглэлүүд байна. ТАЙЛБАР:Дууны бит урсгал нь хамгийн бага декодлолын хэсэг болно.	Дууны фрейм- нэг шахалт хийгдэж кодлогдох 8, 24 мсек эсвэл 48 мсек-д орж ирэх дууны дискретүүдийн тоон урсгал

5-13	Audio mode	Дууны горим	Дууны кодлолын систем нь нэг сувгийн, хоёр сувгийн, стерео ба нийлмэл стерео гэсэн горимуудыг хангана. ТАЙЛБАР: Горим бүрийн бүрэн дууны дохио нь дууны бит урсгалаар кодлогддог.	Дууны горим - үйлчилгээний бүрдэл нь дууны хэдэн сувгийг(зурвас хэмнэхийн тулд моно, олон хэлийнх - давхар/dual, чанарын бага алдагдалтайгаар хурдыг бууруулсан стерео сувгийнх-хамтарсан/joint, параметрэн стерео, спектрийн зурвасын орлуулгатай) агуулж байгааг, дууны сувгуудын зохион байгуулалтыг илэрхийлдэг.
5-14	Audio Service Component Type	ASCTy	Дууны үйлчилгээний нийлэгдэхүүний төрөл	Дууны үйлчилгээний нийлэгдэхүүний төрөл-Аудио үйлчилгээний бүрэлдэхүүн хэсгийн төрөл- Тоон өргөн нэвтрүүлгийн хурдан мэдээллийн сувгийн үйлчилгээний бүрэлдэхүүн хэсгийг тодорхойлох хэсэгт дамждаг бөгөөд тухайн хэсэгт дууны кодлолын төрөл болон сувгийн форматын тухай 6 бит мэдээлэл байна.
5-15	Audio/Data	A/D	Дуу/өгөгдөл	хасах
5-16	Auxiliary Information Channel	AIC	Туслах мэдээллийн суваг. 63 дэд сувгууд нь хурдтай мэдээллийн сувгаас зөөгдөж ирсэн мэдээллүүдийг дахин чиглүүлдэг.	Туслах мэдээллийн суваг. Үндсэн дууны өгөгдлөөс ангид программын нэр тайлбар, дууны нэр, уран бүтээлчийн мэдээлэл, цаг агаарын мэдээлэл, хугацааны синхрончлол, нягтруулгын бүтцийн тухай, зураг лого зэрэг нэмэлт үйлчилгээний мэдээлэл, өгөгдөл дамжуулахад зориулагдсан логик суваг.
5-17	Basic Multilingual Plane	BMP	Хэл сонголтын талбар. Олон хэлний сонголтын хэсэг	олон хэлний суурь хавтан- олон хэлний сонголтын талбар

MNS 6886:2026

5-18	Bit allocation	Битийн хуваарилалт	Психоакустик загварын дагуух дэд зурвасуудад хэсэгчлэн хуваарилсан өөр хугацааны хуваалтын битүүд	Битийн хуваарилалт - Психоакустик загварын дагуу дэд зурвас бүрийн дискретүүдэд хуваарилагдах битийн тоог тогтоох
5-19	Bit-strings	Битийн цуваа	Зүүн талаас эхэлнэ. Программын төрлийг заана. Тухайн мөчид нэвтрүүлэгдэж байгаа зүйлийг зааж "1" эсвэл "0" гэсэн утга авна.	Битийн цуваа- өгөгдлийн нэгжийг илэрхийлсэн битийн дараалал
5-20	Bound	Зааг	Стерео горимын дэд сувгийн дугаар	Зааг- дэд сувгийн эхлэл төгсгөл, дэд сувгийн багтаамжийг тодорхойлогч
5-21	Capacity Unit	CU	Чадамжийн нэгж. Ээлжит солбицлын нийтлэг хүрээ (CIF)-ийн хамгийн бага хаягийн нэгж (64 бит)	Багтаамжийн нэгж (CU) - нэг үйлчилгээ нэг сувагт хуваарилагдсан өгөгдлийн багтаамжийн нэгж (64 бит)
5-22	Change Event Indication	CEI	Үйл явдлын заагчийг өөрчлөх. Өгөгдлийн баазад байх FIG талбарууд нь мэдээллээр шинэчлэгдэж байхыг зохицуулна.	үйлчилгээний мэдээлэлд гарсан өөрчлөлтийг өгөгдлийн санд өөрчлөн тусгасныг илэрхийлэх тодорхой утга бүхий (ямар өөрчлөлт) хурдан мэдээллийн бүлгийн (FIG) талбарын бүрдэл
5-23	Channel number	Chlimit	Сувгуудын дугаар	Сувгийн дугаар
5-24	Common Interleaved Frame	CIF	Энгийн тасалдуулгын фрейм. Үндсэн үйлчилгээний нягтруулга нь тоон цуваа гаралттай бөгөөд энэ нь нэвтрүүлэгчийн фреймийн үндсэн үйлчилгээний сувгийн нэгэн хэсэг ТАЙЛБАР: Нэвтрүүлэгчийн бүх горимд 55 296 бит байна. (ЖИШЭЭ: 864 CU).	сэлгэсэн энгийн фрейм - дамжууллын фреймийн үндсэн үйлчилгээний сувгийн хэсэгт үндсэн үйлчилгээний нягтруулагчаас гарч буй цуваа тоон өгөгдөл

5-25	Conditional Access Identifier	CAId	Нөхцөлт хандалтын дугаар	Нөхцөлт хандалтын танигч - нууцлалтай контентыг нээх эрх бүхий хүлээн авагч буюу хэрэглэгчийн төхөөрөмжийг таних 16 битийн код
5-26	Conditional Access Organization	CAOrg	Нөхцөлт хандалтын байгуулалт	
5-27	Contents Indicator	CI	Агуулга заагч. Ижил төстэй агуулга тэмдэгтээр илэрхийлэх	Дэд суваг эсвэл дууны бүрэлдэхүүн хэсгийн агуулгын төрөл агуулгыг тодорхойлогч (стерео моно яриа хөгжим өгөгдөл) 4 битийн талбар
5-28	Convolutional coding	Мушгиа код	Битийн гажуудлыг засварлах код	Мушгиа кодлол- битийн алдаа засварлах кодлол
5-29	Critical band	Эгзэгтэй зурвас	Психоакустик чихний сонголд тааруулах давтамжийн домайн ТАЙЛБАР: психоакустик хэмжигдэхүүний нэгж нь Bark бөгөөд дууны давтамжийн хуваарьт шугаман бус хуваарилагдана.	Психоакустик загварт зохицсон дууны давтамжийн нэгж хэсэг
5-30	Current/Next	C/N	Одоо/Дараачийнх	Одоо/Дараагийнх
5-31	Cyclic Redundancy Check	CRC	Илүүдлийг шалгах	Илүүдцийг шалгах код - дамжуулж буй өгөгдөлд алдаа гарсан эсэхийг мэдээллийн битийн цуваанд олон гишүүнтийн алгоритм ашиглан алдаа илрүүлэх битүүдийг оруулж хүлээн авах талд тэдгээрийн утгыг шалган алдааг илрүүлж битийн утгыг эсрэгээр өөрчлөх процесс.

MNS 6886:2026

5-32	DAB audio frame	DAB дууны мэдээллийн хүрээ	DAB дууны мэдээллийн фрейм, өгөгдлийн стандартчилагдсан урсгал илгээх талбар	DAB дууны фрейм - декодлол хийхэд шаардлагатай мэдээлэл бүхий дууны шахагдсан дууны өгөгдөл ба толгой мэдээллээс тогтох өгөгдлийн нэгж
5-33	DAB transmission signal	DAB дамжууллын дохио	Нэвтрүүлэгчийн гаралтаас гарах (DAB) радио давтамжийн дохио (радио)	DAB нэвтрүүлэх дохио-DAB фреймээр модуляц хийгдсэн RF дохио
5-34	DAB+			дууны кодлолдоо дууны дэвшилтэт кодлол+, үр ашигт дууны дэвшилтэт кодлол ашигласан тоон дууны өргөн нэвтрүүлгийн сайжруулсан хувилбар
5-35	DAB-Digital Audio Broadcasting			Аналог FM өргөн нэвтрүүлгээс илүү чанартайгаар дуу ба өгөгдлийг тоон хэлбэрт 30МГц-ээс 3ГГц давтамжид суурин зөөврийн хөдөлгөөнт хүлээн авагчуудад олон үйлчилгээг газар, хиймэл дагуул кабелийн аль ч сүлжээгээр найдвартай хүргэх тоон радиогийн технологи
5-36	DAB subchannel			DAB дэд суваг- бие даасан үйлчилгээнүүдийг зөөвөрлөх үндсэн үйлчилгээний суваг (MCS)-ийг хэсэгчилсэн нэгж хэсэг.

5-37	Data service	Өгөгдлийн үйлчилгээ	Дууны бус бусад өгөгдлийн (хоёрдогч) үйлчилгээнүүдийн бүрдэл	Өгөгдлийн үйлчилгээ - дууны өгөгдлийн сувгаас ялгаатай, системийг ажиллуулахад (синхрончлол нягтруулга, дохиолол) болон системээр үзүүлэх нэмэлт үйлчилгээг (цаг агаарын мэдээ, лого) агуулсан үйлчилгээ
5-38	Data Service Component Type	DSCTy	Өгөгдлийн үйлчилгээний нийлэгдэхүүний төрөл	Өгөгдлийн үйлчилгээний нийлэгдэхүүний төрөл - өргөн нэвтрүүлгийн станцын шошго, мэдээ, цаг агаарын мэдээ, цомогтой холбоотой мэдээлэл нягтруулга хугацааны синхрончлол нягтруулга дохиоллын мэдээлэл дамжигдаж байгаа эсэхийг заадал 6 битийн талбар
5-39	Database key	Өгөгдлийн сангийн түлхүүр	FIG талбарууд нь тухайн мэдээллийн онцлогт таарсан өгөгдлийн дэд баазуудад хуваагдана.	Өгөгдлийн сангийн түлхүүр-тодорхой үйлчилгээний мэдээллийн тодорхойлогчийг агуулах өгөгдлийн сангийн хэсгийг тодорхойлогч
5-40	date and time	D&T	Өдөр, цаг	

MNS 6886:2026

5-41	Difference between two Scale Factors	Dscf	Хоёр Scale factor (ScF)-ийн хоорондын ялгаа	Хуваарийн хоёр тогтмолын ялгаа-зэргэлдээ хоёр давтамжийн дэд сувгийн дууны дискретийг квантлах хуваарийн тогтмолын зөрөө. Зэргэлдээ дэд зурвасуудад хуваарийн тогтмол ойролцоо бол эхний дэд сувгийн утгаар хуваарийг тогтмолыг тодорхойлно. Харин эрс өөр байвал 2 дах дэд сувагт шинэ хуваарийн тогтмолыг тооцож гаргана.
5-42	Differential QPSK	Ялгавартай QPSK	Ялгавартай QPSK	Ялгаврын QPSK
5-43	Digital Audio Broadcasting (DAB)	Тоон радио өргөн нэвтрүүлэг	Радио өргөн нэвтрүүлгийн тоон технологийн төрөл	
5-44	Dual channel mode	Хос сувгийн горим	Дууны дохионы горим бөгөөд дууны хос суваг нь тусдаа хоёр программыг дууны 2 сувгаар зэрэг кодолж нэг дууны бит урсгалаар дамжуулах (audio bit stream), Кодлолын процесс нь стерео горимтой адил	
5-45	Dynamic Range Control	DRC	Динамик царын удирдлага	Динамик царын удирдлага- дууны дохионы хамгийн их ба бага түвшний хоорондох ялгааг чанга дууг сулруулах эсвэл сул дууг чангатгах замаар сонсоход таатай болгож тохируулах зорилгоор динамик царын удирдлагын коэффициентуулдын тухай мэдээлэл фрейм бүрд дамжих ба түүгээр дууг сэргээх түвшнийг тохируулдаг.

5-46	Emergency Warning Systems	EWS	Онц байдлын анхааруулгын системүүд	Онцгой байдлын сэрэмжлүүлгийн систем - тоон өргөн нэвтрүүлгийн хүлээн авагчид сэрэмжлүүлгийн дохиог шууд дамжуулах систем
5-47	Energy dispersal	Эрчим хүчний тархалт	Логик фреймийн битийн хэмжээ нь урьдчилан тооцоололтын сонголтоор, нэвтрүүлэгчийн дохионд тааруулан энергийн тархалтын тохируулгатайгаар зохион байгуулагддаг.	Энерги сарниалт-өгөгдлийн нэг тэгийн цуваанд нэг дор олон нэг эсвэл тэг байх энергийн төвлөрлийг сарниулж алдаа гарах магадлалыг бууруулан, алдаа гарсан ч хялбар засах боломжийг олгох зориулалттай үйлдэл
5-48	Ensemble	Нэгдэл	Ортогонал зөөгчүүдийн нэгтгэгдсэн багц дохио. Программ ба үйлчилгээний өгөгдлүүдийг хүлээн авч боловсруулах үүрэгтэй.	Иж бүрдэл- нэг давтамж дээр дамжигдах үйлчилгээнүүдийн нийлбэр цогц .
5-49	Ensemble Identifier	Нэгдэл тодорхойлогч	Олон улсад адил хэрэглэгдэх 16-битийн кодыг нэгдэлд ашиглана.	Иж бүрдлийг таних үг-нягтруулагдсан өгөгдлийн урсгалаас сонгосон иж бүрдлийн өгөгдлийг ялгахад хүлээн авагчид туслах таних үг
5-50	Ensemble info			Иж бүрдлийн мэдээлэл-нягтруулгад орсон бүх үйлчилгээ ба дэд сувгуудын талаарх мэдээлэл бөгөөд хүлээн авагч түүний дагуу декодлох, зөв эрэмбэлэх ялгахад таслах мэдээлэл
5-51	Ensemble transfer interface	ETI	Нэгдэл дамжуулах Интерфейс	Иж бүрдэл дамжуулах интерфейс
5-52	EPG (Electronic Program Guide)			Цахим хөтөч (EPG)-нягтруулгын бүтцэд байгаа үйлчилгээний цагийн хуваарь ба хөтөлбөрийн мэдээлэл

MNS 6886:2026

5-53	error resilience			Алдаанд тэсвэртэй - дамжууллын алдаа гарсан ч дууны контентоо хэвийн сэргээх чадвар
5-54	Equal Error Protection	EEP	Ижил алдааны хамгаалалт. Бит урсгалыг алдаанаас хамгаалах горим	Алдаанаас ижил хамгаалагдах-модуляцийн тэмдэгт бүр эсвэл бит бүр алдаанаас ижил хамгаалах үйлдэл.
5-55	Extended Country Code	ECC	Улсын өргөтгөсөн код	Улсын өргөтгөсөн код-улсын стандарт кодоос илүү нарийвчилсан улсын ба мужийн код
5-56	Fast Information Block	FIB	Хурдтай мэдээллийн блок. Өгөгдлийн багцын хэмжээ нь 256 бит, ТАЙЛБАР: FIB блокуудын дараалал нь Хуртай мэдээллийн сувгаар (FIC) зөөгддөг. FIB-ийн бүтэц нь нэвтрүүлэгчийн бүх горимд нийтлэг ижил байна.	Хурдан мэдээллийн блок - иж бүрдлийн бүтэц, шошго ба таних үгнүүд, нөхцөлт хандалтын мэдээлэл, ачааллын мессежний суваг (TMC) зэрэг өгөгдлийн сонголтын үйлчилгээг агуулах хурдан мэдээллийн сувгийн дамжууллын суурь нэгж. FIB нь 256 бит(32 байт) - ийн тогтмол хэмжээтэй нэг ба түүнээс олон FIC-ээс тогтоно.
5-57	Fast Information Channel	FIC	Хурдан мэдээний суваг. Энэ нь нэвтрүүлэгчийн фреймийн нэг хэсэг ба FIB- үүдийг агуулдаг. Олон төрлийн мэдээллийн конфигурацыг агуулж, сонголтод үйлчилгээний мэдээллийг өгөгдлийн нэгтгэлээс авах боломжийг бүрдүүлнэ.	Хурдан мэдээллийн суваг- Нэгдсэн урсгалаас сонгосон программын хэсгийг ялгаж декодлоход шаардлагатай хяналт ба дохиоллын мэдээллийг дамжуулах суваг. FIC=map+instruction Нягтруулгын бүтцийн тухай (MCI), үйлчилгээний мэдээлэл (SI), мэдээллийн (TMC) өгөгдөл агуулна.

5-58	Fast Information Data Channel	FIDC	Хурдтай мэдээллийн өгөгдлийн суваг. FIC-ийн заагдсан хэсэгт өгөгдлийн үйлчилгээний холбогдолтой мэдээллүүд дамжина. Жишээлбэл: пэйжирийн холболт	Хурдан мэдээллийн өгөгдлийн суваг - MSC дотор сонголтоор дамждаг ачааллын мессежний суваг (TMC), тэмдэглэл (journaline), динамик шошгын сегмент (DLS) зэрэг мэдээлэл дамжих хэрэглэгчийн өгөгдлийн үйлчилгээний суваг.
5-59	Fast Information Group	FIG	Хурдтай мэдээллийн групп. FIC-д багц өгөгдлийн хэсэгт нэг зорилготой мэдээллийн FIC -ийг илгээх зорилгоор ашиглах. Үүнд 8 төрлийн ангиллыг үүсгэн ашиглах боломжтой.	Хурдан мэдээллийн бүлэг- FIB -ийн өгөгдлийн нэгж бөгөөд иж бүрдэл ба үйлчилгээний мэдээлэл, дэд сувгийн зохион байгуулалт, үйлчилгээний шошго, нөхцөлт хандалтын мессеж, ачааллын мессежний суваг (TMC)-ийн мэдээлэл орно. FIB доторх мессежийг FIG -ээс тогтоно
5-60	Fixed Programme Associated Data	F-PAD	Тогтмол программын холбоотой мэдээлэл. PAD-ийн тодорхойлон заасан хэсэгт багтах DAB-ийн дууны фреймийн сүүлийн 2 байт	Тогтсон программтай холбоотой өгөгдөл - Тухайн програмын статик (программын дамжууллын явцад өөрчлөгддөггүй) мэдээлэл агуулсан өргөн нэвтрүүлгийн программтай хамт дамждаг мета өгөгдөл.
5-61	FEC			Алдааг шууд засварлах-дамжууллын явцад гарсан алдааг дахин дамжуулал шаардахгүйгээр хүлээн авах талд шууд засахад зориулагдсан алдаа илрүүлэх битүүдийг нэмэх үйл явц

MNS 6886:2026

5-62	Frequency Information	FI	Давтамжийн мэдээлэл	Давтамжийн мэдээлэл - дамжуулал хэрхэн зохион байгуулагдаж тодорхой иж бүрдлийг хэрхэн олж авах тухай мэдээлэл. Иж бүрдэл нь давтамжийн тодорхой блокт дамжуулагддаг бөгөөд нягтруулгын бүтцийн мэдээлэл дотор хурдан мэдээллийн сувагт дамжина. Үүнд нэг бүр нь 1.536 МГц-ийн зурвастай давтамжийн блок, энэ блокийн төвийн давтамж, тухайн давтамж дээрх иж бүрдлийг таних үг зэрэг мэдээлэл багтана.
5-63	Granule of three sub- band samples per sub- band	Gr	Дэд зурвасын хэсэг	Дэд зурвас бүрд 3 хэсэглэгдсэн дэд царын дискретын хугацааны үргэлжлэл. Богино үргэлжлэлтэй байвал хугацааны нарийвчлал өндөр, дууны богино өөрчлөлтөд мэдрэг харин урт үргэлжлэлтэй байвал өөрчлөлт багатай тогтонги дууны хувьд тохирох бөгөөд давтамжийн нарийвчлал сайн байна.
5-64	Intensity stereo coding	Эрчимтэй стерео кодлол	Дууны стерео программыг чанарын өндөр төвшинд байлгах зорилготой аргачлал (нөөцийн ба сайжруулалт)	Эрчимийн стерео кодлол- Стерео сувгийн баруун ба зүүн сувгийн дохиог шууд кодлохгүйгээр өндөр давтамжид энэ 2 сувгийн фазын зөрөөг хүний сонсголын эрхтэн муу мэдэрдэг шинж чанарт тулгуурлан тэдгээрийн нийлбэрийг (L+R) ба зүүн баруун сувгийн хооронд энергийг хуваах харьцааг тогтоох ялгавар (L-R) дохиог кодлож дамжуулах арга .
5-65	Interleaving depth			Сэлгээний гүн-өгөгдлийн байршлыг тараан өөрчлөх фреймийн тоо Тухайлбал 15 фреймийн гүнтэй сэлгээ гэдэг нь тухайн фреймын өгөгдөл 15 фреймийн дараа дамжигдана гэж ойлгоно.

5-66	Joint stereo mode	Хамтарсан стерео горим	Хоёр сувгийн стерео хос нэг тоон урсгал болон дамжуулагдах аргачлал	Стерео 2 сувгийн дамжууллын илүүцийг арилгаж илүү үр ашигтай кодлол хийх зорилготой Дунд ($M=L+R$) ба хажуугийн ($S=L-R$) кодлолын аргын ерөнхий нэршил. Түүний нэг төрөл нь Эрчимийн стерео кодлол -ISC
5-67	Journaline			Тэмдэглэл-тоон өргөн нэвтрүүлгийн системээр дамжиж буй мэдээний ба мэдээллийн текстэн үйлчилгээ
5-68	logical frame	Логик хүрээ	Дэд сувгийн агуулга оролцох хэсэг бөгөөд хугацааны интервал нь 24 мс байдаг.	Логик фрейм-Дууны өгөгдлийн суурь нэгж Дэд зурвасын дууны дискретүүд, битийн хуваарилалт ба хуваарийн тогтмол, стерео кодлолын мэдээлэл, алдаа засварын битүүдийг агуулсан өгөгдлийн хамгийн жижиг нэгж.
5-69	logical frame count	Логик хүрээний тоолуур	Логик хүрээ тоолуур нь эхний CIF-ээс тоолоход оролцоно.	Логик фреймийн тоо - дууны нэг фреймд дамжигдах логик фреймийн тоо (0-23 хүртэл) Энэ нь алдаатай фреймийг илрүүлэх, битийн хуваарилалт, стерео кодлол хийхэд хэрэглэгдэнэ.
5-70	Logical Frame Number	LFN	Логик фреймийн дугаар	Логик фреймийн дугаар - DAB-ийн нэг дууны фрейм дэх логик фреймүүдэд олгогдсон дугаар. Үүгээр декодлох тал логик фреймүүдийн дарааллын дагуу нэг фреймд харгалзах дискретүүдийг сэргээнэ

MNS 6886:2026

5-71	Main Service Channel (MSC)	Үндсэн үйлчилгээний суваг	Энэ суваг нь нэвтрүүлэгчийн фреймийн үндсэн хэсэг ба дууны бүх үйлчилгээний бүрдлийг зөөвөрлөнө.	Үндсэн үйлчилгээний суваг-дуу ба түүнтэй холбоотой өгөгдлийн үйлчилгээ буюу контентын өгөгдөл дамжих суваг
5-72	MER -(Modulation Error Ratio):			Модуляцийн алдааны харьцаа -хүлээн авч буй тоон модуляцтай дохионы чанарын хэмжээс бөгөөд төгс модуляцтай дохионы чадлыг хүлээн авагдсан дохионы төлөвийн диаграммын алдааны чадалд харьцуулсан харьцаа DAB-ийн хувьд 25дБ-ээс их, DVB-T-ийн хувьд 30дБ-ээс их байх нь сайн гэсэн үнэлгээ. Сайн MER байна гэдэг нь битийн алдаа цөөхөн, тогтвортой хүлээн авалт, дохионы чанар сайн байгааг илтгэнэ.
5-73	MPEG audio			MPEG дуу- MPEG-ийн дууны кодлол-8 мсек (I түвшин) , 24 мсек (II түвшин) , 8 ба 24 мсек (III түвшин) хугацаанд орж ирсэн дууны 384 дискрет ба 1152 дискретийг нэг фрейм болгон багцалж шахах технологи
5-74	Multichannel audio			олон сувгийн дуу-стерео ба олон сувгийн (стерео эсвэл 5.1 7.1 13.1 олон сувгийн дуу) дууг кодолж дамжуулсан.

5-75	Multiplex Configuration Information	MCI	Нягтруулгын бүтцийн мэдээлэл. Энэ нь үйлчилгээний тухайн үеийн нарийн мэдээллүүдийг (дамжиж байгаа мэдээлэлд) дахин тохиргоо хийж байгаа мөн дараачийн тохиргоо г.м) үүнд үйлчилгээний бүрэлдэхүүн хэсэг, дэд сувгууд системийн хэсгүүдийн холбоос зэргийг дамжуулдаг.	Нягтруулгын бүтцийн мэдээлэл- энэ нь нэг иж бүрдэлд орж байгаа үйлчилгээнүүд, дууны сувгууд, тэдгээрийн багтаамж ба декодлоход хэрэгтэй мэдээллүүдийг агуулсан, хурдан мэдээллийн сувагт дамждаг удирдлагын мэдээлэл бөгөөд иж бүрдлийн мэдээлэл (Ensemble ID label country ID), үйлчилгээний мэдээлэл (service ID label service type), дэд сувгийн мэдээлэл (subchannel ID, MSC start address, length, protection level) үйлчилгээний бүрдлийн мэдээллийг (audio or data component, coding type, bitrate) зэргийг агуулна
5-76	Multiplex -MUX			MUX-дууны олон суваг болон өгөгдлийн нэг урсгалд нэгтгэж радио дамжуулал хийх арга
5-77	Music/Speech	M/S	Хөгжим/яриа	
5-78	Null symbol	Тэг тэмдэгт	Orthogonal Frequency Division Multiplex (OFDM)-ын эхний тэмдэгтийг нэвтрүүлэгчийн фреймд тодорхойлно.	Дамжууллын фреймийн эхийг заадаг , тэг битүүдээс тогтох OFDM тэмдэгт
5-79	Number of allocated bits per sub-band sample	Nbal	Дэд зурвас бүрийн хуваарилалтын дугаар	Дэд зурвас бүрийн дискретэд хуваарилагдсан битийн тоо
5-80	Number of channels; equal to 1 for single channel mode, 2 in other modes	Nch	Сувгийн дугаар “1” үед нэг сувгийн горим, “2” үед бусад горим	Сувгийн тоо - нэг сувагтай үед 1 утгатай, бусад тохиолдолд 2 утга авна.

MNS 6886:2026

5-81	OFDM symbol	OFDM тэмдэгт	Хугацааны тухайн хэсэгт модуляцлагдах фазын төлөв	OFDM-ийн ортогональ бүх дэд зөөгч дээр нэгэн удаа нэгэн зэрэг хуваарилагдаж модуляцлагддаг нэг иж бүрдлийн битийн урсгалыг хамгаалах завсрын хамтад нь хэлнэ. Модуляцлагдсаны дараа ижил агууригтай ижил зайд алслагдсан иж бүрдлийн тэмдэгтүүдэд харгалзах ижил фазын төлөвтэй байх хугацааны хэсэгт дамжиж буй дохио
5-82	Packet mode	Багцын горим	Хаяглагдсан блокоос дуудагдах багцын горимыг заана. ТАЙЛБАР: MSC-ээр өгөгдлийн группийг дамжуулахад дэд сувагтай ашиглагдана.	өгөгдөл нь багц гэж нэрлэгдэх өгөгдлийн хаяглагдсан блокоор дамжуулагддаг өгөгдөл дамжууллын горим
5-83	PAD	Program Associated Data		Программтай холбоотой өгөгдөл-тухайн үйлчилгээтэй холбоотой нэмэлт мэдээлэл тухайлбал цомгийн нэр, дуучны нэр гэх мэт
5-84	Polyphase filter bank	Олон фазын шүүрийн банк	Олон фазын шүүрийн банк	Дэд зөөгчийн спектрийг хэлбэржүүлэх, зөөгч хоорондын интерференцийг бууруулахын тулд IFFT-ийн өмнө ба дараа дэд зөөгийг шүүх үйлдлийг нэвтрүүлэх талд, ирж буй олон сувгийг салгаж FFT хийхэд бэлтгэх зорилгоор дэд зөөгчүүдийн ортогональ шинжтэйгээр үүсгэх, зурвасын гаднах цацаргалтыг бууруулдаг ижил зурвасын өргөнтэй шүүрийн бүрдэл
5-85	Primary service component	Анхдагч үйлчилгээний нийлэгдэхүүн	Үйлчилгээний эхний бүрдэл. ТАЙЛБАР: Хүлээн авагчууд дээр үйлчилгээг таних сонголт хийгддэг.	Анхдагч үйлчилгээний нийлэгдэхүүн-үйлчилгээний эхний бөгөөд үндсэн байгуулагчууд

5-86	Primary/Secondary	P/S	Анхдагч /хоёрдогч	
5-87	Programme	Программ	Программын хуваарийн дагуу хүлээн авахад зориулагдана.	программын хуваарьт оруулахтай холбоотой программын үйлчилгээний хугацааны зүсмэл/ хэсэг
5-88	Programme Associated Data	Программын холбоотой өгөгдөл	Дууны өгөгдлийн мэдээллүүд ба агуулга, синхронизацийн төлөвүүдийг заана. ТАЙЛБАР: PAD нь DAB-ын дууны фреймийн төгсгөлд байршина.	Программтай холбоотой өгөгдөл- контентын дууны өгөгдөл ба синхрончлолтой холбоотой мэдээлэл
5-89	Programme item	Программын зүйл	Тухайлсан төрлийн программыг хүлээн авах цагийг тодорхойлох зориулалттай.	Программын зүйл-хөгжим эсвэл мэдээ гэх мэт программын 1 төрөл зүйлд харгалзах хугацааны нэг хэсэг
5-90	Programme service	Программын үйлчилгээ	Дууны үндсэн үйлчилгээний бүрдэлд ордог бөгөөд хоёрдогч үйлчилгээний бүрдэлд оруулж ашиглах боломжтой.	Программын үйлчилгээ-дууны үндсэн үйлчилгээ ба сонголтоор явах нэмэлт хоёрдогч үйлчилгээний бүрдэл хэсэг
5-91	Protection level	Хамгаалах төвшин	Нэвтрүүлэгчийн дамжууллын алдааны эсрэг мушгиа код ба хамгаалалтын төвшнийг тодорхойлогч	Хамгаалах түвшин-мушгиа кодлол зэргээр дамжууллын алдаанаас хамгаалах зэргийг тодорхойлох түвшин
5-92	Protection profile	Хамгаалах профил	Мушгиа кодын схем	Хамгаалах профил-Мушгиа кодлолын схемийг тодорхойлогч
5-93	Psychoacoustic model	Психоакустик загвар	Хүний дуу сонсох системийн математик загвар	Хүний сонсголын эрхтний хаах шинж чанарыг илэрхийлэх математик загвар
5-94	Pulse Coded Modulation (PCM)	Импульс кодын модуляц	Тоон дохионы кодлолын арга	эндээс хасах
5-95	Remainder polynomial coefficients, highest order first	Rpchof	Олон гишүүнчлэлийн коэффициент ба их утга нь эхэндээ ашиглагдана	Олон гишүүнтийн хамгийн их нь эхнийх байх үлдэгдэл коэффициент

MNS 6886:2026

5-96	Service component data group	Үндсэн үйлчилгээний сувгийн өгөгдлийн бүлэг	MSC-д хэрэглэгчийн аппликешн ашиглахад оролцох үүрэгтэй. ТАЙЛБАР: MSC өгөгдлийн хэсгүүд нэг ба хэд хэдэн хэсгүүдийн багцад дамжих бөгөөд эсвэл X- PAD өгөгдлийн дэд талбарт дамжуулагдана.	Үндсэн үйлчилгээний сувгийн өгөгдлийн бүлэг- DAB өгөгдлийн үйлчилгээний нэг үйлчилгээний байгуулагчийн өгөгдлийн нэгж бөгөөд үндсэн үйлчилгээний сувгийн дотор өгөгдлийн үйлчилгээний байгуулагчийн өгөгдөл дотор дамжина.
5-97	Scale Factor	ScF	Хуваарийн коэффициент. Квантлахаас өмнө өгөгдөх дугаарлалт	Хуваарийн тогтмол - Квантлахын өмнө нэг цонхонд орж ирж буй дууны дискретүүдийн агууригийн утгаас тогтоосон тогтмол тоо б өгөөд түүний хоёртын утгыг хуваарийн тогтмолын индекс гэнэ.
5-98	Scale Factor Select Information	ScFSI	Хуваарийн коэффициентийг сонгох мэдээлэл. 2-битийн код бөгөөд хэдэн Scale Factor-оос дууны фрейм тогтохыг заана.	Хуваарийн тогтмолын сонголтын мэдээлэл - дууны фреймийн дотор тухайн дэд зурваст хэдэн хуваарийн тогтмол кодлогдсон тухай 2 битийн мэдээлэл
5-99	Secondary service component	Хоёрдогч үйлчилгээний нийлэгдэхүүн	Үндсэн үйлчилгээнээс гадна (дууны үйлчилгээ) нэвтрүүлэх бусад нэмэлт үйлчилгээнүүд	Хоёрдогч үйлчилгээний нийлэгдэхүүн - үйлчилгээ нь үндсэн үйлчилгээний нийлэгдэхүүнээс илүү үйлчилгээг агуулж байвал нэмэлт үйлчилгээний байгуулагч нь хоёрдогч үйлчилгээний нийлэгдэхүүн болно.
5-100	Service	Үйлчилгээ	Хэрэглэгчийн сонгож ашиглах гаралт хөтөлбөрийн үйлчилгээ эсвэл өгөгдлийн үйлчилгээг сонгож ашиглах боломжтой	Үйлчилгээ- өгөгдлийн эсвэл дууны программын хэрэглэгчээр сонгогдох гаралт

5-101	Service component	Үйлчилгээний нийлэгдэхүүн	Үйлчилгээний нийлэгдэхүүн нь дууны эсвэл өгөгдлийн байна. ТАЙЛБАР: Үйлчилгээний бүрдлүүд (нийлэгдэхүүнүүд) Нягтруулгын конфигурацын мэдээлэлд холбогдох ба үйлчилгээ бүрийн нийлэгдэхүүнүүд нь дэд- сувгаар болон Хурдтай мэдээллийн өгөгдлийн суваг) (FIDC)-ээр аль алинаар нь зөөгдөнө.	Үйлчилгээний нийлэгдэхүүн - дуу эсвэл өгөгдлийг агуулах үйлчилгээний хэсэг
5-102	Service Component		Үйлчилгээний нийлэгдэхүүн	хасах
5-103	Service Component identifier			Үйлчилгээний бүрдлийг таних үг- сонгогдсон үйлчилгээний бүрэлдэхүүн хэсгүүдийг (дуу, өгөгдөл) ялгах таних үг
5-104	Service Identifier	Sid	Үйлчилгээ тодорхойлогч. 16-бит эсвэл 32- битийн кодыг тухайн үйлчилгээний тодорхойлогчоор ашиглана.	Үйлчилгээг таних үг- нягтруулагдсан өгөгдлийн урсгалаас сонгосон сувгийн үйлчилгээний өгөгдлийг ялгахад хүлээн авагчид туслах таних үг
5-105	Service Information	SI	Үйлчилгээний мэдээлэл. Үйлчилгээнүүдийн мэдээллийг программчилсан кодоор: үсэг тоон тэмдэгтүүдээр хүлээн авагчийн дэлгэц дээрх тухайлсан үйлчилгээг: дууны декодерыг удирдахад зориулж кодолсон мэдээллийг тэмдэглэсэн	үйлчилгээний шошго ба программын хэлбэрийн код зэрэг үйлчилгээний тухай нэмэлт мэдээлэл

MNS 6886:2026

5-106	Service label	Үйлчилгээний тэмдэглэгээ	Үйлчилгээнүүдийн мэдээллийг программчилсан кодоор: үсэг тоон тэмдэгтүүдээр хүлээн авагчийн дэлгэц дээрх тухайлсан үйлчилгээг: дууны декодерыг удирдахад зориулж кодолсон мэдээллийг тэмдэглэсэн	үйлчилгээний шошго - хүлээн авагчийн дэлгэцэд үзүүлэх зориулалт бүхий тухайн үйлчилгээтэй холбоотой цагаан толгойн тэмдэгтүүд
5-107	Service transfer interface	STI	Үйлчилгээ Дамжуулах Интерфейс	
5-108	Side information	Туслах (бусад) мэдээлэл	Үйлчилгээнүүдийн мэдээллийг программчилсан кодоор: үсэг тоон тэмдэгтүүдээр хүлээн авагчийн дэлгэц дээрх тухайлсан үйлчилгээг: дууны 58декодерыг удирдахад зориулж кодолсон мэдээллийг тэмдэглэсэн	Туслах мэдээлэл -дууны декодлуурыг хянах удирдахад чиглэх кодлогдсон дууны битийн урсгал доторх битийн хуваарилалт, хуваарийн тогтмолын сонголтын мэдээлэл хуваарийн тогтмол зэрэг мэдээлэл.
5-109	Single channel mode	Нэг сувгийн горим	Дууны горим ба дууны моно программыг илэрхийлж 1 битээр кодлогдоно.	Нэг сувгийн горим- нэг битийн урсгал болж кодлогдсон нэг моно дууны программын горим
5-110	Single Frequency Network	SFN	Нэг давтамжийн сүлжээ. DAB нэвтрүүлэгчийн нэг давтамжит сүлжээ нь өргөн уудам газар нутгийг хамарсан хамрах хүрээг байгуулахад ижил радио давтамжийн зурвасыг ашигласан нэвтрүүлэгчүүд зэрэг ажиллана.	Нэг давтамжийн сүлжээ. өргөн уудам газар нутгийг хамарсан сүлжээг үүсгэхийн тулд DAB нэвтрүүлэгчүүд бүгд ижил радио давтамжийн зурваст ижил OFDM тэмдэгтийг нэгэн зэрэг дамжуулах горим
5-111	Slideshow (Dynamic Label segment)			Динамик шошгын сегмент- Дууны контенттой холбоотой дүрс ба текстийг үзүүлэх үйлдэл

5-112	SNR			Дохио шуугианы харьцаа-Модуляцийн гажуудлыг тооцохгүйгээр дохионы чадлыг шуугианы чадалд харьцуулсан харьцаа бөгөөд дохионы чанарын хэмжээс
5-113	Stereo mode	Стерео горим	Энэхүү дууны горимд, хоёр сувгийн стерео хос (баруун, зүүн) дохио нийлж, нэг бит урсгал болон кодлогдоно. Dual channel mode (Хос сувгийн горим)-той адил төстэй юм.	Стерео горим - баруун ба зүүн сувгийн дууны дохиог кодлож нэг битийн урсгалаар дамжуулдаг программын горим
5-114	Stream mode	Урсгалын горим	Үүсгүүрүүдээс өгөгдлүүд Үндсэн үйлчилгээний сувагт зөөгдөж ирнэ. ТАЙЛБАР:Өгөгдлүүд логик фреймээр зөөгдөнө.	Үндсэн үйлчилгээний сувгийн дотор үүсгүүр ба хүлээн авах цэгийн хооронд өгөгдлийг нэвт дамжуулах горим . Өгөгдөл нь логик фреймд агуулагдаж дамжина.
5-115	Stuffing	Дүүргэлтийн битүүд	Нэг ба түүнээс олон битүүд дууны бит урсгалд нэгдэнэ. ТАЙЛБАР:Энэ битүүд нь дууны декодлолд орохгүй бөгөөд зөвхөн шаардлагатай үед өгөгдлийн дүүргэлт хийхэд зориулагдана.	Нөхөлт/гүйцээлтийн битүүд -дууны битийн урсгалд оруулах нэг эсвэл түүнээс олон битүүд
5-116	Sub-band	Дэд зурвас	Дууны радио давтамжийн хэсгүүд ТАЙЛБАР: дууны кодлолын системд ижил зурвасын өргөнтэй 32 дэд зурвас ашиглагдана.	Дэд зурвас - дууны давтамжийн зурвасын хэсэгчлэгдсэн нэгж. Тухайлбал ижил хэмжээтэй 32 давтамжийн дэд зурваст хуваадаг.
5-117	Sub-band samples	Дэд зурвасын самнасан утгууд буюу дискрет утгууд	Шүүсэн хэсгүүд нь самнасан утга буюу дискрет утга гэж нэрлэгдэнэ.	дэд зурвасын дискретүүд - Оролтын дууны дохионы дискретлэгдсэн шүүгдсэн дэд хэсэг. 1 дэд зурвасын шүүрийн гаралтанд гарч буй дискретийг агуулна.

MNS 6886:2026

5-118	Sub-channel	Дэд суваг	Үндсэн үйлчилгээний сувгийн хэсэг (Main Service Channel) нь мушгиа кодоор кодлогдох бөгөөд дугаарлагдана	бие даан тусдаа мушгиа кодлол хийгддэг сэлгэсэн фрейм бүрд багтаамжийн нэгжүүдийн бүхэл тоон нийлбэрээс тогтох үндсэн үйлчилгээний сувгийн хэсэг
5-119	Synchronization channel	Синхрончлолын суваг	Дамжууллын фреймийн энэ хэсэг нь фазын мэдээлэл агуулж синхрончлолыг хангахад зориулагдана.	Синхрончлолын суваг-фазын тулгуурийг агуулах дамжууллын фреймийн хэсэг
5-120	Syncword	Синхрон үг	12-битээр MPEG дууны II төвшний бит урсгал ISO/IEC 11172-3 [3], ISO/IEC 13818-3 стандартаар дууны фреймийн эхлэлийг таниулдаг.	дууны фреймийн эхлэлийг таниулах ISO/IEC 11172-3 [3], ISO/IEC 13818-3 стандартын MPEG дууны II түвшний битийн урсгал дотор агуулагдах 12 битийн код
5-121	The number of the lowest sub-band for which no bits are allocated	Sublimit	Хамгийн богино sub-band-уудын дугаар (дэд зурвасын хязгаар буюу лимит)	Дэд хязгаар -битүүд хуваарилагдахгүй хамгийн бага дэд зурвасын тоо
5-122	Time interleaving	Хугацаагаар алгасалт	Системийг илүү үр ашигтай, хурдан найдвартайгаар өгөгдөл боловсруулах, хугацаагаар алгасах процесс. Ж: Өгөгдлийн холбоонд санах ойн алдаагүй ажиллагаа явуулахад энэ арга ашиглагдана.	Хугацааны сэлгээ-Дохионы унтралт, багцаас үүсэх багц алдааг бууруулахын тулд өгөгдлийг хугацаагаар нь тараан байрлуулах өөрөөр хэлбэл дараалсан байтуудын байрлалыг сэлгэх үйлдэл
5-123	Transmission Coding and Multiplexing			Дамжууллын кодлол ба нягтруулга - санамсаргүйжүүлэгч, мушгиа кодлол, хугацааны сэлгээ, давтамжийн сэлгээ зэрэг үйлдлүүд хийгддэг тоон радиогийн сувгийн кодлол нягтруулга

5-124	Transmission frame	Дамжууллын хүрээ	Дамжууллын фрейм нь 4 дамжууллын горимд ажиллах ба Синхрончлолын суваг (Synchronization Channel), Fast Information Channel, Main Service Channel гэсэн сувгуудтай	Дамжууллын фрейм-Синхрончлолын суваг, Хурдан мэдээллийн суваг, үндсэн үйлчилгээний суваг зэргийг зөөвөрлөх 4 дамжууллын горим бүхий дамжууллын фрейм
5-125	Transmission mode	Дамжууллын горим	Дамжууллын багц параметрууд (ж:зөөгчийн тоо, OFDM) ТАЙЛБАР:Системийн сүлжээ, конфигурац, радио давтамжийг заана.	Дамжууллын горим-дамжууллын параметр үзүүлэлтүүдийн (зөөгчийн тоо, OFDM тэмдэгтийн үргэлжлэл) тусгайлсан бүрдэл
5-126	Unequal Error Protection	UEP	Алдааны ижил бус хамгаалалт. Бит урсгалын хэсгүүдийн алдаанаас хамгаалах процедурыг агуулна	Алдааны ижил бус хамгаалалт - битийн урсгалын ялгаатай хэсгүүдийн бит алдааны мэдрэмжид тохируулан алдаа засварлах арга хэрэглэх
5-127	Unsigned integer, most significant bit first	Uimbsf	Scale Factor (ScF) сонголтын мэдээлэл. Хамгийн чухал бит нь эхэнд нь	
5-128	User Application	UA	Энэ нь өгөгдлийн аппликейшн(нэг зэрэг 6 аппликейшнийг MSC дууны үйлчилгээнд зөөвөрлөнө.)	DAB -аар явуулах янз бүрийн стандарттай өгөгдлийн аппликейшн (хэрэглэгчийн нэг аппликейшнд нэг FIDC, MCS багц эсвэл урсгалын өгөгдлийн үйлчилгээ хамаарна)
5-129	X-PAD data group	X-PAD өгөгдлийн групп	Өргөтгөсөн программын холбоотой өгөгдөл (X-PAD)-дахь багц өгөгдөл	X-PAD өгөгдлийн групп - өргөтгөсөн программтай холбоотой мэдээлэл дотор нэг хэрэглэгчийн аппликейшнд хэрэглэгдэх өгөгдлийн багц

3.6 Хиймэл дагуул

№	Англи нэр	Монгол нэр	Тайлбар	Засварлах санал
6-1	Attitude	Байрлал	Тогтоосон тэнхлэгийн дагуу байгаа хиймэл дагуулын байрлал	Өндөр -тулгуур түвшнээс дээш өргөгдсөн объектын босоо чиглэл дэх зай. Хэрэв тулгуур өндөр нь далайн түвшин бол бол далайн түвшнээс өргөгдөх хиймэл дагуулын байрлалын өндөр . Дэлхийн гадаргуу дээрх аль нэг цэгийн умардаас өмнө зүг рүү байрлалыг тодорхойлсон газар зүйн солбицол
6-2	Autotracking	Өөрөө дагагч	Хиймэл дагуулын байрлалыг автоматаар дагаж тодорхойлох систем	автомат мөшгөлт-хиймэл дагуулыг антены үндсэн цацрагт буюу дэлбээнд багтаах зорилготой үндсэн навчны хөдөлгөөн Хиймэл дагуулын байрлалыг автоматаар дагаж тодорхойлох систем
6-3	Azimuth	Азимут	Ажиглагчийн байгаа газраас огторгуйн биет хүртэлх шугам болон хойд чиглэл хоорондын өнцөг. Антены хэвтээ чиглэлийн координат	+
6-4	Beam	Цацраг	Радио долгионыг хүчтэй бөөгнүүлсэн нэг чигийн урсгал хэмжээ нь дэлхийн гадаргуу дахь хамрах хүрээгээр тодорхойлогдоно	Цацраг- дэлхийн гадарга дээр хамрах хүрээг тодорхойлогч радио долгионы эрчмийг төвлөрүүлсэн урсгал

MNS 6886:2020

6-5	Boresight		Хүлээн авах антены хиймэл дагуулаас ирэх дохиог хамгийн их хэмжээгээр хүлээн авах байрлал	үндсэн тэнхлэг - хурц чиглэлтэй антены цацрагийн хамгийн их утгын чиглэлээр буюу антеныг тохируулах мөшгөх тэнхлэг
6-6	C-Band	C-Band зурвас	Хиймэл дагуулын телевизийн суурин үйлчилгээ болон өгөгдөл дамжуулахад зориулагдсан зурвас. 3.4 ГГц-7.025 ГГц	
6-7	Digital Satellite Equipment Control	DiSEqC	Тоон хиймэл дагуулын төхөөрөмжийн хяналт	Хиймэл дагуулын тоон төхөөрөмжийн хяналт/тохируулга
6-8	Digital Satellite News Gathering	DSNG	ENG болон SNG хоёрын нийлмэл бүтэцтэй хөдөлгөөнт холбооны бүтэц	Тоон хиймэл дагуулын мэдээ цуглуулах систем-дурын байршлаас шууд нэвтрүүлэг эсвэл өргөн нэвтрүүлгийн дуу дүрс өгөгдлийг телевизийн төв рүү хиймэл дагуулаар дамжуулах үүрэгтэй зөөврийн болон тээврийн хэрэгсэл дээр суурилагдсан хиймэл дагуулын өгсөх урсгалын систем. Дотроо мэдээний электрон цуглуулах систем (ENG), хиймэл дагуулын мэдээ цуглуулах систем (SNG) агуулна. Мэдээний контент бэлдэх илгээхдээ зөөврийн камер мик, бичигч зэрэг электрон хэрэгслүүд ашиглахыг ENG, бичлэгийн контент ба шууд дамжууллын контентыг хиймэл дагуулын өгсөх урсгалыг ашиглан ТВ-ийн төв рүү

				дамжуулахыг SNG гэнэ.
6-9	DirectTo Home	DTH	Хиймэл дагуулаас шууд хүлээн авах антены тусламжтай олон суваг ба бусад үйлчилгээг хүлээн авах	Гэрт шууд хүргэх систем - өргөн нэвтрүүлгийн дохиог геотогтонги хиймэл дагуулаас хүлээн авах антен, тюнер, STB-ийн тусламжтай шууд хүргэх хиймэл дагуулын ТВ-ийн контентыг түгээх арга
6-10	Dish antenna	Тавган антен	“Парабол антен”-ыг хар	Тавган антен - хиймэл дагуулаас ирж буй радио долгион руу чиглэсэн нарийн цацраг бүхий парабол ойлгогчтой антен
6-11	Downlink	Буух шугам	Хиймэл дагуулаас өгөгдлийг газрын станц, төгсгөлийн төхөөрөмж рүү дамжуулах уруудах шугам	Буух/уруудах шугам- Сансрын нэвтрүүлэх станцаас газрын хүлээн авах станц эсвэл хэрэгсэл рүү радио долгион дамжуулдаг радио шугам.
6-12	Earth Station	Газрын станц	Холбооны төхөөрөмж болон антенаас бүрдсэн хиймэл дагуулаас дохиог хүлээн авах эсвэл цацах зориулалттай станц	Дэлхийн гадарга дээр, эсвэл дэлхийн атмосферийн үндсэн хэсэгт байрласан ба дараах холбоонд зориулагдсан станц - Нэг, эсвэл түүнээс олон станцтай; - Нэг, эсвэл түүнээс олон хиймэл дагуул, эсвэл сансарт байрласан биетүүдийн тусламжтайгаар нэгэн төрлийн нэг буюу түүнээс олон станцтай.

MNS 6886:2020

6-13	Elevation	Өргөлт	Антенy чиглэлийг өргөх өнцөг. Босоо чиглэлийн координат	Тухайн газар нутгийн хэвтээ гадаргуу ба түүн дээр байрласан антенy хиймэл дагуул эсвэл бусад объект руу чиглэсэн үндсэн цацрагийн хоорондох өнцөг
6-14	Fixed Satellite Service	FSS	ОУЦХБ-аас тодорхойлсон хиймэл дагуулаас хөдөлгөөнгүй газрын станцыг хангаж байгаа төрөл бүрийн үйлчилгээ	хиймэл дагуулын суурин үйлчилгээ - газар дээрх тогтмол байрлалтай төхөөрөмж ба геостационар хиймэл дагуулын хооронд холбооны суурин үйлчилгээ явуулах хиймэл дагуулын холбооны үйлчилгээ.
6-15	Footprint	Хиймэл дагуулын хамрах хүрээ	Дэлхий дээр дохио тархаж байгаа бүс, хамрах хүрээ	(тухайлсан гадаргуу дээрх антенy цацрагийн) тусгал/мөр - Антенy тусгайлсан хамгийн бага өсгөлтийн түвшнээс их түвшинтэй цацрагийн нэг хэсэг ба гадаргуугийн огтлолцлоор үүсэх хүрээгээр хүрээлэгдсэн тухайлсан гадаргуу
6-16	Frequency Division Multiple Access	FDMA	Давтамжийн хуваалттай олон хандалт	Давтамжийн хуваалттай олон цэгийн хүртэмж/хандалт-боломжит давтамжийн зурвасыг олон дэд сувгуудад хувааж дэд суваг бүр нэг хэрэглэгчид хуваарилагдаж олон хэрэглэгч өөр өөр дэд суваг дээр бие даасан нэгэн зэрэг дамжуулал хийх арга

6-17	Geosynchronous	Геосинхрончлол той	Дэлхийтэй харьцуулахад хөдөлгөөнгүй байрлалтай хиймэл дагуулын тойрог зам	Геосинхрончлолтой- Дэлхийн тэнхлэгийн эргэлттэй синхрон эргэлдэх хиймэл дагуул. ТАЙЛБАР: Дэлхийн эргэлтийн оддын үе нь 23 цаг 56 минут орчим байдаг.
6-18	Global Positioning System	GPS	Хиймэл дагуулд суурилсан байршил тогтоох систем	Дэлхий дээрх байршил тогтоох систем- хиймэл дагуулд суурилсан, дэлхий дээрх байршлыг тогтоох, навигац болон хугацааны синхрончлолын тасралтгүй үйлчилгээ үзүүлэх сансрын сегмэнт (24 ба түүнээс олон МEO дагуул) газрын сегмэнт (хиймэл дагуулыг хянах мөрдөх газрын станц, хиймэл дагуулаас ирэх дохиогоор байрлал, хурд, хугацааг тооцоолох хэрэглэгчийн хүлээн авагч)-аас тогтох систем.
6-19	High Powered Amplifier	HPA	Модуляцлагдсан дохиог өсгөж хиймэл дагуул руу цацах зориулалттай их чадлын төхөөрөмж	их чадлын өсгүүр - газрын станц дээрх эсвэл транспондер дээр модуляцтай дохиогоор өдөөгдөж дохиог чадлаар нь өсгөх хэрэгсэл.
6-20	Integrated Receiver Decoder	IRD	Хүлээн авагч, декодер хосолсон хиймэл дагуулын дохио хүлээн авагч төхөөрөмж	хиймэл дагуулаас дохиог хүлээн авч демодуляц, декодлож дамжууллын урсгалыг ялгаж дэлгэц дээр дүрс дуу өгөгдлийг гаргах хэрэглэгчийн эсвэл мэргэжлийн хэрэгсэл

MNS 6886:2020

6-21	Interfacility Link	IFL	Газрын станцын холбооны төхөөрөмж болон антен хооронд байрлах шугам	Байгууламж хоорондын шугам - өргөн нэвтрүүлгийн байгууламжийн (студиас нэвтрүүлэгч хүртэл, студиас толгой станц хүртэл, эсвэл бүс нутгуудын студи хоорондын) хооронд дуу дүрс өгөгдөл хугацааны синхрончлол болон удирдлага хяналтын дохиог дамжуулах зориулалттай оптик, релей, T1/E1-ийн түрээсийн, Этернэт , IP/MPLS-ийн зэрэгийн алт нэг төрлийн холбооны шугам
6-22	Ka-Band	Ka-Band зурвас	Хиймэл дагуулын телевизийн суурин үйлчилгээ болон өгөгдөл дамжуулахад зориулагдсан бөгөөд хоёр чиглэлийн өргөн зурвасын үйлчилгээ үзүүлэхэд зориулагдсан зурвас. 17.3 ГГц-30 ГГц	26.5-40ГГц-ийн давтамж дээрх бичил долгионы зурвас бөгөөд сансрын холбооны системд өндөр нэвтрүүлэх чадвартай шугам, VSAT, цөм сүлжээ, өргөн зурвасын үйлчилгээ явуулах зориулалттай. хоёр чиглэлийн өргөн зурвасын үйлчилгээ үзүүлэхэд зориулагдсан зурвас.
6-23	Ku-Band	Ku-Band зурвас	Хиймэл дагуулын телевизийн суурин үйлчилгээ болон өгөгдөл дамжуулахад зориулагдсан зурвас. 10.7 ГГц-14.5 ГГц	Ku зурвас - 12-18ГГц-ийн давтамж дээрх бичил долгионы зурвас бөгөөд DTH, VSAT, хиймэл дагуулын мэдээ цуглуулах систем болон суурийн хиймэл дагуулын үйлчилгээ

6-24	Latitude	Өргөрөг	Дэлхийн гадаргуу дээрх аль нэг цэгийн умардаас өмнө зүг рүү байрлалыг тодорхойлсон газар зүйн солбицол	хасах
6-25	Left hand polarised wave	LHC (P)	Зүүн гарын чиглэлд туйлширсан долгион	зүүн гарын туйлшралтай долгион цагийн зүүний эсрэг туйлшралтай долгион нар буруу туйлшралтай долгион Тархалтын чиглэл байрлаагүй дурын хавтгай дээрх цахилгаан орны урсгалын нягтын вектор тархалтын чигт харахад хугацаанаас хамаарч зүүн гарын буюу цагийн зүүний эсрэг эргэлт хийж байгаа зууван туйлшралтай долгион
6-26	Longitude	Уртраг	Дэлхийн гадаргуу дээрх аль нэг цэгийн дорноос өрнө зүг рүү байрлалыг тодорхойлсон газар зүйн солбицол	+
6-27	Low Earth Orbit	LEO	Хиймэл дагуулын доод түвшний тойрог зам (нам орбит). Дэлхийгээс ойролцоогоор 400-900 км-ын зайд алслагдана	Дэлхийн гадаргуугаас ойролцоогоор 160-2000 км өндөрт байрлах хиймэл дагуулын тойрог замыг хэлнэ. Энэ тойрог замд буй дагуулууд бага саатал, өндөр өгөгдөл дамжуулах хурд, ойролцоогоор 90-120 минутын тойрог хугацаатай байдаг.

MNS 6886:2020

6-28	Low Noise Block	LNB	Хиймэл дагуулаас ирсэн өндөр давтамжтай радио долгионы дохиог нам давтамжтай радио долгионы дохионд хувиргах бага шуугиантай төхөөрөмж	Бага шуугианы блок- хүлээн авах байгууламжийн антен дээр голдуу байрладаг хиймэл дагуулаас буюу алсаас ирж буй дохиог хүлээн авч өсгөөд завсрын гэж нэрлэгдэх бага давтамж руу хувиргаад хүлээн авагчийн дараагийн блокт (магадгүй хоёр дах завсрын давтамжийн хувиргуур руу эсвэл завсрын давтамжийн өсгүүр рүү) дохиог дамжуулдаг шуугианы температур багатай блок
6-29	Medium Earth Orbit	MEO	Хиймэл дагуулын дундаж түвшний өндрийн тойрог зам. Дэлхийгээс ойролцоогоор 1000 км-ээс дээш зайд алслагдана	Дэлхийн гадаргуугаас ойролцоогоор 2 000–35 786 км өндөрт байрлах хиймэл дагуулын тойрог зам.
6-30	Orbital	Тойрог замын	Тойрог замын	шаардлагагүй
6-31	Parabol antenna	Парабол антен	Радио долгионыг чиглүүлэх зориулалттай парабол гадаргуутай, ойлгогч антен. Тавган антен гэж бас нэрлэдэг	Радио долгионыг ойлгох гадаргуу нь парабол хуулиар өөрчлөгддөг чиглүүлэх чадвар өндөр гадаргуун антен
6-32	Pitch	Pitch	Хиймэл дагуулын хамрах хүрээг өрнө болон дорно чиглэлд шилжихэд хүргэдэг таталцлын хүчнээс шалтгаалсан хөдөлгөөний нэр	+Объект (нисэх онгоц, хиймэл дагуул, антен) хөндлөн тэнхлэгийнхээ дагуу дээш доош эргэх хөдөлгөөн. → нисэх биетийн хамар нь дээшилж өлийх эсвэл тонгойх хөдөлгөөн

6-33	Pointing angles	Заасан өнцгүүд	Дэлхийн гадаргуугийн аль нэг цэгээс хиймэл дагуулын байршлыг босоо, хэвтээ гэсэн хоёр өнцгөөр тодорхойлох	Чиглэл тогтоох/заах өнцөг- антены босоо ба хэвтээ тэнхлэгийн өнцөг ба хиймэл дагуул эсвэл дэлхий дээрх газрын станц газрын хүлээн авагчийн байрлаж буй цэгт чиглэсэн зорилтот чиглэлийн хоорондох өнцөг.
6-34	Positioning	Байршил тогтоох	Координатын дагуу шилжүүлэх, байрлалыг тодорхойлох	Объектын байрлалыг тулгуур координатын системд жишээ нь газарзүйн өргөрөг, уртраг, өндөр зэрэгт тулгуурлан тооцоолж тогтоох үйл явц.
6-35	Propagation Delay	Тархалтын хоцролт	Дохио хиймэл дагуулд хүрээд буцаж дэлхийд ирэх нийт хугацаа	Тархалтын хугацааны саатал-Хиймэл дагуулын өргөн нэвтрүүлгийн системд дохио газар дээрх газрын станцын нэвтрүүлэгч → хиймэл дагуул → газрын станцын хүлээн авагч хүртэл тархан дамжихад зарцуулагдах нийт хугацаа.
6-36	Radar	Радар	Аливаа орон зай дахь биетийг радио долгионы тусламжтай илрүүлэх, хоорондын зайг тодорхойлох систем	Радио долгион ашиглан объектын байршил, зай, хурд, чиглэлийг тодорхойлж объектыг илрүүлэх систем.

MNS 6886:2020

6-37	Right hand polarised wave	RHC(P)	Баруун гарын чиглэлд туйлширсан долгион	баруун гарын туйлшрал цагийн зүүний дагуу туйлшрал нар зөв туйлшрал Тархалтын чиглэл байрлаагүй дурын хавтгай дээрх цахилгаан орны урсгалын нягтын вектор тархалтын чигт харахад хугацаанаас хамаарч баруун гарын буюу цагийн зүүний дагуу эргэлт хийж байгаа зууван туйлшрал.
6-38	Roll	Roll	Хиймэл дагуулын хамрах хүрээг умард болон өмнөд чиглэлд шилжихэд хүргэдэг таталцлын хүчнээс шалтгаалсан хөдөлгөөний нэр	+Объект (нисэх онгоц, хиймэл дагуул, антен) уртын тэнхлэгийнхээ дагуу баруун-зүүн тийш эргэх хөдөлгөөн. → Нэг далавч дээшилж, нөгөө нь доошилдог хөдөлгөөн гэж төсөөлж болно.
6-39	Satellite Broadcasting	Хиймэл дагуулын өргөн нэвтрүүлэг	Харилцаа холбооны зориулалттай хиймэл дагуулаас радио долгионыг ашиглан өргөн нэвтрүүлгийн дохиог дамжуулж парабол антенаар хүлээн авдаг систем	Хиймэл дагуулаас радио, телевиз эсвэл өгөгдлийн дохиог дэлхий дээрх өргөн газар нутагт хамарч нэгэн зэрэг үйлчлэх харилцаа холбооны арга.
6-40	Satellite Master Antenna TV	SMATV	Зочид буудал, бүлэг хүмүүс амьдардаг байр, барилгад зориулсан кабелийн телевизийн үйлчилгээ	Газрын нэг эсвэл олон станцаар хүлээн аваад олон хэрэглэгчид (барилга, хотхон, зочид буудал гэх мэт) дотоод сүлжээгээр нь түгээх телевизийн систем

6-41	Satellite Orbit	Тойрог зам	Хиймэл дагуулын тойрог зам	<p>Хиймэл дагуул дэлхийн (эсвэл өөр тэнгэрийн биетийн) таталцлын нөлөөгөөр тогтвортой шилжиж эргэлдэх зам. Байгалиас үүсэлтэй хүч ялангуяа татах хүчний үйлчлэлээс хамаарах ба сансар дахь хиймэл дагуул буюу бусад биетийн хүндийн хүчээр тодорхойлогддог тусгайлсан хүрээнд хамаарах зам</p> <p>2. Шаардлагатай замыг бий болгон цаашид ашиглахын тулд байгалиас үүсэлтэй хүч ба давших хөдөлгөөнтэй хэрэгслээс үүсэх бага энергитэй засах хүчнээс хамаарч сансрын биетийн хүндийн хүчээр тодорхойлогдох зам.</p> <p>ТАЙЛБАР: Радио зөвлөмжид дээрх хоёр тодорхойлолтыг нэгтгэн дараах байдлаар томъёолсон байна (RR176): “Байгалийн хүч, ялангуяа таталцлын хүчнээс хамаарах ба сансрын биетийн хүндийн төвөөр тодорхойлогдох тусгайлсан хүрээнд хамаарах зам”</p>
6-42	Satellite Spectrum	Хиймэл дагуулын спектр	Олон Улсын Цахилгаан Холбооны Байгууллагаас гаргасан хиймэл дагуулын холбоонд ашиглах зориулалттай	+

MNS 6886:2020

			тодорхой давтамжийн зурвас	
6-43	S-Band	S-Band зурвас	Хиймэл дагуулын телевиз, радиогийн өргөн нэвтрүүлэгт буюу нисэх онгоцны нислэгийн үеийн холболтод зориулсан зурвас. 1.97 ГГц- 2.69 ГГц	+
6-44	S-DAB	S-DAB зурвас	Суурин ба хөдөлгөөнт төхөөрөмжүүдэд зориулсан тоон дууны өргөн нэвтрүүлгийн зурвас. 1.467 ГГц- 1.492 ГГц	+
6-45	Simulcast	Simulcast	Нэгэн зэрэг нэвтрүүлэг хийх	нэгэн зэрэг дамжуулал- ижил контентыг олон платформ эсвэл олон сувгаар нэгэн зэрэг дамжуулах үйл явц
6-46	Site Diversity	Байрлалын ялгаа	Борооноос болж унтралт үүсэхэд ашигладаг хоорондоо зайтай хоёр болон түүнээс дээш тооны терминалууд ашиглах арга	сайтын ялгавартай дамжуулал - Харилцаа холбооны системийн найдвартай байдлыг нэмэгдүүлэхийн тулд нэг дохиог газарзүйн хувьд өөр өөр байршилтай хэд хэдэн станцаар дамжуулах буюу хүлээн авах арга.
6-47	SNG	Satellite News Gathering	Парабол антен хиймэл дагуул хооронд 2 чиглэлийн мэдээний дүрс, дуу дамжуулах, хүлээн авах зориулалттай, тээврийн хэрэгсэл дээр суурилсан хөдөлгөөнт холбооны бүтэц	тээврийн хэрэгсэл дээр суурилсан хөдөлгөөнт эсвэл зөөврийн төхөөрөмжөөр бичлэгийн контент ба шууд дамжууллын контентыг хиймэл дагуулын өгсөх урсгалыг ашиглан ТВ-ийн төв рүү дамжуулах

6-48	Sun Transit	Нарны давхцал	Хиймэл дагуулаас ирж байгаа дохиог тасалдах эсвэл гажуудуулахад хүргэдэг газрын станцтай харьцуулахад хиймэл дагуулын чанх ард нар орох үзэгдэл	Нарны давхцал - + Нар антен болон хиймэл дагуулын хооронд нэг шугамд давхцан байрлах үед нарны цацрагийн улмаас хүлээн авч буй дохио түр хугацаанд саатах эсвэл алдагдах үзэгдэл.
6-49	Transponder	Транспондер	Телевиз, радиогийн өргөн нэвтрүүлэг, интернэт, сансрын холбоог дамжуулах C, Ku, Ka давтамжийн багц	Хиймэл дагуул дээр байрлах антенаар хүлээн авсан дохиог өсгөж, давтамжийг нь хувирган буцаан дамжуулах радио төхөөрөмж.
6-50	Uplink	Өгсөх шугам	Газрын станцаас өгөгдлийг хиймэл дагуулд дамжуулах өгсөх шугам	Газрын нэвтрүүлэх станц ба сансрын хүлээн авах станц хоорондын радио шугам. ТАЙЛБАР 1: Энэ нэр томъёо нь газрын холбоонд ашиглагддаг нэвтрүүлэх хөдөлгөөнт станц ба хүлээн авах бааз станц хоорондох шугам. ТАЙЛБАР 2: Өгсөх шугамыг доороос дээшээ чиглэсэн сумаар тэмдэглэдэг.
6-51	Very Small Aperture Terminal	VSAT	Тавган антены хэмжээ нь 3,8 метрээс доош овортой 2 чиглэлийн, хиймэл дагуулын газрын станц	3.5 метрээс бага диаметртэй антен ашиглан хиймэл дагуултай хоёр чиглэлт өгөгдөл дамжуулах зориулалттай газар дээрх харилцаа холбооны терминал
6-52	Yaw	Yaw	Хиймэл дагуулын хамрах хүрээг цагийн зүүний дагуу эсвэл эсрэг шилжихэд хүргэдэг таталцлын хүчнээс	+

НОМ ЗҮЙ

Харилцаа Холбооны Хууль 2001 оны 10-р сарын 18-ны өдөр

Радио долгионы тухай хууль 1999 оны 6-р сарын 4-ны өдөр

Мэдээлэл холбооны технологийн англи-монгол толь бичиг, *Доктор, профессор Б.Сүхбаатар, ШУТИС, ХМТС,*

Мэдээлэл, харилцаа холбооны технологийн англи нэр томъёоны тайлбар, *Доктор, профессор Н.Чулуунбанди, Доктор Т.Лхагвасүрэн, Г.Дугарчулуун, Э.Батцэцэг, Б.Золзаяа,*

<https://www.mediacollege.com/glossary/>.MediaCollege.com Free educational website for all forms of electronic media

<http://www.rfwireless-world.com/> RF Wireless World website is a home of RF and Wireless Vendors and Resources

<http://iabmglossary.com/> IABM-International trade association for suppliers of broadcast and media technology.

<https://www.afterdawn.com/glossary/> AfterDawn.com-branded tech information sites